

## **ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХҮМҮҮЖИЛ, ТӨЛӨВШИЛ, ЁС СУРТАХУУНЫ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Д.Халиун, Д.Жигваагүнсэл, Р.Нургүл*

### **АГУУЛГА**

#### **УДИРТГАЛ**

Нэг. Гадаадын зарим орны ерөнхий боловсролын хүрээнд ёс суртахуун, иргэний боловсрол олгодог туршлага

1.1. Европын зарим улс орнуудын ёс суртахууны боловсрол олгож буй туршлага

- ХБНГУ
- Итали
- Франц
- Бельги
- Финланд
- Норвег

1.2. Ази, номхон далайн зарим улс орнуудын ёс суртахууны боловсрол олгож буй туршлага

- Япон
- Шинэ Зеланд
- БНСУ
- Энэтхэг
- Бутан
- Сингапур

Хоёр. Ерөнхий боловсролын сургуульд ёс суртахууны боловсрол олгохоор хууль, бодлогын баримт бичигт тусгасан улс орнуудын туршлага

- 2.1. ОХУ
- 2.2. Казахстан
- 2.3. АНУ

#### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

**Судалгааны хамрах хүрээ:** Тус судалгаанд гадаадын зарим орны ерөнхий боловсролын тогтолцоонд ёс суртахуун, ёс зүйн боловсрол олгодог туршлага, мөн хүүхэд, залуучуудад дотоод сэтгэлийн боловсрол олгохоор хуульчилсан улс орнуудын эрх зүйн орчныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалсан болно.

Судалгааны *Нэгдүгээр хэсэгт* ерөнхий боловсролын сургуульд иргэний боловсрол, ёс суртахууны хичээлийг хэдэн наснаас, ямар түвшинд олгодог талаар зарим Азийн улс орнуудын туршлагыг судалсан болно. Судалгааны *Хоёрдугаар хэсэгт* хүүхэд, залуучуудад дотоод сэтгэл, ёс суртахууны боловсрол олгохоор бодлогын баримт бичиг, хууль тогтоомжоор журамласан ОХУ, БНКа.У, АНУ зэрэг орны туршлагыг судалсан болно.

**Судалгааны үр дүнгийн тойм:** Ёс зүй, дотоод сэтгэлийн боловсролыг судалгаанд хамрагдсан Ази, Номхон далайн орнууд болох БНСУ, Сингапур, Япон, Энэтхэг, Бутан, Шинэ Зеланд зэрэг улсын боловсролын салбарын хууль эрх зүйн орчны хүрээнд судлан үзэхэд дотоод сэтгэлийн боловсролыг<sup>49</sup> олгох тухай тусгайлан зохицуулсан хууль, дүрэм, журам байхгүй хэдий ч ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрүүдэд ёс зүй (ethics), ёс суртахуун (morals), иргэний болон зан суртахууны боловсрол, зан суртахуун ба иргэншил (civic and character education/character and citizenship education гм.)<sup>50</sup>-ийн боловсролын

<sup>49</sup>дотоод сэтгэлийн боловсрол – нэр томъёоны хувьд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт байхгүй хэдий ч бусдыг энэрэн нигүүлсэх сэтгэлийг ойлгож байна. “Орчин үеийн боловсрол 200 гаруй жил хөгжиж, техник, технологи, материаллаг дэвшилд их анхаарч харин сэтгэлийн боловсролд сайн анхаарсангүй. Хүн хүнээ хайрлах, энэрэх дотоод сэтгэлийн боловсрол олгох хэрэгцээтэй болов.” (О. Пүрэв, Боловсролын хүн судлал ба суралцагчийн хүмүүншил, хөгжил, Боловсролын хүрээлэн, <https://humanities.mn/fileman/Uploads/ltgel/2016-2017/hawar/3-purev.pdf>)

<sup>50</sup>Иргэний боловсролын хичээл Ерөнхий боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг судалгааны тайланд “Иргэний боловсрол”-ыг дараах байдлаар тайлбарласан байна. Иргэний боловсрол хэмээх ойлголт нь Civic education, Citizenship education хэмээх хоёр ойлголтоор илэрхийлэгддэг бөгөөд боловсролын харилцаанд янз бүрийн утгаар хэрэглэгдэж байна. Зарим судлаач “civic education” буюу иргэний боловсрол нь хүүхэд, залуучуудыг нийгмийн идэвхтэй гишүүн болгон бэлтгэх боловсролын салбар, харин “citizenship” буюу иргэншил нь тухайн нийгмийн гишүүд иргэн болон төлөвших үйл явцыг тэмдэглэсэн ойлголт хэмээн ялган үздэг байна.

НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО)-аас 1987 онд “Хүний эрхийн сургалт, мэдээлэл ба баримт бичиг” сэдвээр Мальт Улсад зохион байгуулсан олон улсын бага хурлаас НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хандан “бүх иргэн, хүн амын бүлэгт хүртэх боломжтой хүний эрхийн боловсрол, сургалтын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатайг гишүүн улс орнуудын анхааралд хүргэн”, “түүх, иргэний боловсрол зэргийн хөтөлбөрт хүний эрхийн агуулгыг тусгаж, зөрчлийг энхийн замаар шийдвэрлэх, хүчирхийллийн бус стратегийг боловсруулах, улмаар гишүүн орон бүрийн тухайн боловсролын талаарх амжилт ололтыг 5 жил тутамд үнэлж байх” талаар зөвлөжээ.

1999 онд хэрэгжүүлсэн Иргэний боловсролын олон улсын харьцуулсан судалгаанд хамрагдсан улс орнууд Иргэний боловсролтой холбогдох зорилго, зорилтуудыг янз бүрээр тодорхойлдог болохыг онцолжээ. Тэдгээрийг тоймлон үзвэл дараах хэдэн зорилт илүү нийтлэг байна:

- Хувь хүний чадавх, бололцоог нэмэгдүүлэх;
- Тэгш бололцоог дэмжих;
- Залуу үеийг ажил хөдөлмөрт бэлтгэх;
- Цаашдын буюу дээд боловсрол эзэмших үндэс суурийг тавих;
- Мэдлэг, чадвар, ойлголт бий болгох;
- Иргэншил буюу ардчилал ба нийтлэг хэм хэмжээнд суралцуулах;
- Соёлын өв уламжлалаа хадгалах, эдлэх явдал зэрэг болно.

Үүнээс үзэхэд иргэний боловсрол нь хүний эрх, ардчилал, улс төр, иргэн - төрийн харилцаа, шийдвэр гаргах үйл явцын талаар мэдлэг эзэмших, чадвар, хандлагаа хөгжүүлэх үйл явцыг багтаасан, олон бүрэлдэхүүн хэсэг бүхий насан туршийн боловсрол юм. Иргэний боловсролын агуулгад мөн плюрализм, олон соёлт орчин, угсаатны ба соёлын өв уламжлал, нийгмийн ялгарал, хүлээцтэй хандах байдал, нийгмийн зүй ёс, үндэсний онцлог, ухаалаг байдал, байгаль орчны ач холбогдлын мэдрэмж зэрэг олон шинэлэг асуудал тусдаг байна. Хүн нийгмийн амьдралын олон талт харилцаанд оролцдог учир тухайн хүнд нийгмийн харилцааны үндэс суурь, зарчмууд, үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдлэг, ойлголт байх шаардлагатай. Тиймээс иргэний боловсролын хичээлийн агуулга нь улс төр, эдийн засаг, нийгэм, ёс суртахуун, соёлын гэсэн 5 үндсэн ай (домайн)-н хүрээнд боловсрогдож, эдгээрийн талаар

хичээлийн агуулгад тусгагдсан гэж үзэж болохоор байна. Дээрх хичээлүүд нь суралцагч, өсвөр үе, залуучууд өөрсдийн эрх, эрх чөлөөгөө мэдэж, шийдвэр гаргах үйл явцад оролцох, байр сууриа илэрхийлэх чадвараа хөгжүүлэхэд туслах, оролцоо бүхий нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх, залуучуудын ёс суртахууны ухамсар, ёс суртахууны зан байдлыг хөгжүүлэхэд чиглэж байна.

Түүхэн уламжлалаар дотоод сэтгэлийн боловсролыг сүм хийд олгож ирсэн байдаг. Дээрх азийн орнуудын хувьд өдгөө улсын ерөнхий боловсролын сургуульд шашны боловсрол олгох (Бутанаас бусад нь олгодоггүй) нь төдийлөн нийтлэг бус байх ба ёс суртахуун, иргэний боловсролын хичээл болон бусад хичээлийн хүрээнд шашны талаарх ойлголтыг өгдөг бол хичээлээс гадуурх хөтөлбөрийн хүрээнд, эсхүл хувийн сургуулиуд нь шашны сургалт явуулах эрхтэй байна.

Европын орнуудын хувьд Азийн орнуудтай харьцуулахад ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс суртахуун, иргэний боловсролын хичээлүүдээс гадна шашин судлалын хичээл орох нь харьцангуй түгээмэл байна. Судалгаанд хамрагдсан Европын 31 улсаас 14-т нь ёс суртахуун, зан суртахуунд чиглэсэн бие даасан хичээлийн хүрээнд заадаг бол 17 улс нь бусад хичээлийн судлах сэдвийн хүрээнд олгодог байна.

ОХУ нь хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны асуудлыг зохицуулах тусдаа хуульгүй, харин хүүхэд, гэр бүлийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулах хууль, дүрэм журам болон хөтөлбөрийн хүрээнд зохицуулдаг. ОХУ-ын Засгийн газар 2015 онд *“2025 он хүртэл ОХУ-ын хүмүүжлийн боловсролын хөгжилд баримтлах стратеги”-ийг* (Стратегия развития воспитания в Российской Федерации на период до 2025 года) батлан гаргасан. Стратеги нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, 1998 оны “Оросын Холбооны Улсын хүүхдийн үндсэн эрхийн баталгааг хангах тухай” хууль (“Об основных гарантиях прав ребёнка в Российской Федерации”), 2012 оны “Оросын Холбооны Улсын боловсролын тухай” хууль (“Об образовании в Российской Федерации”) болон бусад холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах зорилготой. Стратеги нь хүүхдийн хүмүүжлийн талаарх төрийн нэн тэргүүний бодлого, хүмүүжлийн боловсролыг хөгжүүлэх үндсэн чиг хандлага, уг стратегийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг тодорхойлох, түүнчлэн орос иргэнийг илэрхийлэх хувь хүнийг төлөвшүүлэх, нийгэм дэх ёс суртахууны үндэс суурийг

зохио мэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэх нь зүйтэй хэмээн судлаачид үздэг байна.

Дэлхийн улс орнуудад “Иргэний боловсрол”-ын агуулгыг олон хичээлийн хүрээнд багтаан олгодог. Тухайлбал, нийгмийн ухаан, нийгэм судлал, дэлхий судлал, хүн ба нийгэм, амьдралын ухаан, албан ахихуй, хүний эрхийн боловсрол, ёс зүйн боловсрол, эрх зүйн боловсрол зэрэг олон хичээлийн хүрээнд улс орнууд өөрийн иргэддээ орчин үеийн нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, ёс суртахууны харилцааны үндсийг заан сургаж, тэдгээр харилцаанд үр ашигтай оролцох талаар зохио чадвар, хандлагыг төлөвшүүлж иржээ. Түүнээс гадна иргэний боловсрол нь түүх, газар зүй, эдийн засаг, улс төр судлал, байгаль орчин судлал, шашин судлал, төрөлх ба гадаад хэл зэрэг бусад хичээлүүдтэй харилцан холбогдож, иргэдийг нийгмийн харилцаанд бэлтгэхэд дэмжлэг үзүүлдэг байна.

Иргэний боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг, Судалгааны тайлан, ННФ. УБ., 2011. 68-70 дахь тал

бэхжүүлэх, хүүхдийг үр дүнтэй нийгэмшүүлэх, Оросын Холбооны Улс дахь олон үндэстний үнэт зүйл болон ёс заншил, соёлыг судалж таних, хүндэтгэлтэй хандахыг зорилгоо болгосон байна.

Казахстаны хувьд хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны боловсролын тухай тусдаа хууль байхгүй, харин хөтөлбөрийн хүрээнд зохицуулсан байна. 2010 оноос хүүхэд, залуучуудад хүмүүжил, төлөвшил, ардын өв уламжлал, ёс суртахууны боловсрол олгох “*Өөрийгөө таних*” хөтөлбөрийг боловсролын системд нэвтрүүлэн хэрэгжүүлж эхэлсэн байна. Үүнээс өмнө тус хөтөлбөрийг цэцэрлэг, сургууль, коллеж, их, дээд сургуулийг хамарсан нийт 184 байгууллагад 9 жилийн туршилтын шугамаар хэрэгжүүлж, сайжруулан боловсруулж хангалттай сайн үр дүн гарсныг үндэслэн улсын хэмжээнд боловсролын системд нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

АНУ-ын хувьд ерөнхий боловсролын сургуулиудад Character education буюу Зан суртахууны боловсролын хичээлийг заавал судлах хичээлийн тоонд оруулсан (18) болон хөхиүлэн дэмжихээр (18) хуульчилсан 36 муж улс байгаа бол 7 муж улс нь хуулиар тогтоогоогүй боловч бусад баримт бичгийн хүрээнд дэмжихээр тогтоосон, 8 муж улс нь дээрхтэй холбоотой ямарваа нэгэн хууль эрх зүйн зохицуулалтгүй байна.

### ***Ёс суртахуун ба өрнө, дорнын соёлын чиг хандлага***

Ёс суртахууны боловсрол дахь зан заншил, уламжлал нь ёс суртахуун хийгээд, ёс суртахууны боловсролд юуг нийтээр хүлээн зөвшөөрсөн гэж үзэх вэ? юуг тухайн соёлд хамааралтай хэм хэмжээ гэж үзэх вэ? зэрэг суурь асуудлуудыг хөндөх юм. Үүнийг олон талаас, олон янзын онолоор тайлбарласан байдаг. Тухайлбал, нийгэм-танин мэдэхүйн онол, түүнчлэн бүтцийн хөгжлийн онолыг дэмжигчид нь ёс суртахуун нь нийтлэг шинж чанартай бөгөөд гүн ухааны ёс суртахууны ойлголтоос үүдэлтэй гэж тайлбарладаг. Тус онолоор ёс суртахуун гэж байдаг бол түүнийг олон бүлэг хүмүүс, үндэстэн, угсаатнуудын дунд тархааж болох үнэт зүйлсээс бүрдэнэ гэж тайлбарладаг. Нөгөө талаас, угсаатан зүй судлаачид нийгэмшлийн онолыг дэвшүүлдэг ба энэ нь угсаатнууд үнэт зүйлсээ удам дамжин өвлүүлдэг, мөн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлсийг үндэстэн, угсаатнууд бүлэг хүмүүс тайлбарлах байдал нь ялгаатай байдаг гэж үздэг байна. Тухайлбал, зарим судлаачид<sup>51</sup> “ёс зүйн релятивизм” (ёс суртахууны ойлголт нь янз бүрийн цаг хугацаа, нөхцөлд харьцангуй шинжтэй) буюу янз бүрийн угсаатнууд, ёс суртахууны цар хүрээ, хязгаарыг харилцан адилгүй байдлаар тогтоодог гэж үздэг байна. Дээрхийн эсрэг түүхэнд хүмүүс аливааг нэг үндэстэн, угсаатанд хамаарах байдлаас үл хамааран дотоод итгэл үнэмшлээрээ шударга ёсны төлөө тэмцэж байсныг жишээ болгон ёс суртахууны нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг ёс суртахууныг соёлын уламжлалд хамааралгүй гэж үзсэн байдаг. Мөн зарим судлаачид соёлын уламжлал нь ёс суртахуунд бүхэлд нь бус харин ёс суртахууны үнэт зүйлсийн эрэмбэ дараалалд хамаарна гэж үзэж байна. Энэ “ёс суртахууны ойлголт”

<sup>51</sup>Шведер, Махапатра, Миллер зэрэг



(үнэнч, шударга гм) нь нийтлэг ойлголт боловч ёс суртахууны үнэт зүйлсийг үндэстэн, угсаатан, соёлоос хүлээн авах, чухал гэж үзэх эрэмбэ дараа нь ялгаатай байдаг гэж үздэг байна. Ёс суртахууны соёлын ялгаатай байдал нь мэдээллийг ялгаатай байдлаар хүлээн авч тайлбарладаг, мөн дэлхий ертөнцийг үзэх үзлийн ялгаатай байдлын үр дүнд үүснэ. Хүмүүс өөрсдийн үйлдэл, үйл ажиллагаанаас гарах үр дүнгийн талаарх ялгаатай ойлголттой байгаа нөхцөлд ёс суртахууны нэг хэм хэмжээний хүрээнд авч үзсэн хэдий ч тэдгээр үйлдэл, үйл ажиллагааны зөв, шударга гэж үзэх нь ялгаатай байж болно.

Ийнхүү хүүхдийн ёс суртахууны хүмүүжилд соёлын уламжлалыг тооцох, оролцуулах ёстой юу? гэдэг асуулт гарч ирэх ба үүний тулд “уламжлал”, “угсаатан” зэрэг ойлголтыг авч үзэх шаардлагатай болно. “Уламжлал” гэдэг ойлголт нь нэлээд өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд нийгмийн олон асуудлыг багтааж байдаг. Ихэнхдээ уламжлалыг удаан хугацааны турш тухайн угсаатан, нийгмийн бүлэгт үе дамжин уламжлагдаж ирсэн тухайн нийгэм болон соёлын өвийн нэгэн элемент гэж үздэг. Угсаатан болон үндэстэнг уламжлалт болон динамик гэж хоёр ангилах нь элбэг. Уламжлалт үндэстэн, угсаатан дунд үе солигдох болгонд амьдралын цикл буюу мөчлөгт томоохон өөрчлөлт гардаггүй. Энэ төрөлд анхдагч соёл иргэншлүүд болох эртний Египет, Энэтхэг, Хятад зэрэг орно. Энэтхэг, Хятад хоёр нь сүүлийн хэдэн мянган жилийн турш өөрсдийн нийгэм-соёлын тогтолцоог хэвээр хадгалж ирсэн байдаг. Дээрх соёлуудад уламжлалт ёс заншлаа дагах гүн үзэл, хөдөө аж ахуйн хэмнэлд суурилсан хөгжлийн мөчлөгт шинж чанар, байгалийн, эсхүл нэгэнт тогтсон тогтолцоо, хэв маягаа хадгалах байдал, “абсолют” буюу гол төлөв шашнаас гаралтай үнэт зүйлсийг баримжаа болгосон зэрэг шинжүүд ажиглагдана.

Харин динамик улс, үндэстэн нь инновацийг тухайн үндэстэн угсаатны соёлын тэргүүлэх/давамгайлж буй ойлголттой зөрчилдөхгүй нөхцөлд одоо мөрдөж буй уламжлалын хөгжил гэж үздэг байна. Бусад соёлын үзэл санааг амархан, эрчимтэй нутагшуулж, шингээж, өөрийн болгодог, эсхүл өөрийн өв соёлтой зөрсөн, зөрчилдсөн тохиолдолд эсэргүүцэн түлхдэг байна. “Динамик” улс, үндэстэнд ихэвчлэн үе хоорондын зөрчил ихээр ажиглагддаг ба залуу үе нь өмнөх үеэсээ ялгаатай байна. Энэ хэлбэрт хүмүүсийн амьдралын хэв маяг, цаг тооцоолол нь мөчлөг бус шугаман хэлбэртэй байх ба байгалиас үүсэлтэй хэв журмыг шаардлага гарвал, эсхүл зарим тохиолдолд шаардлагагүйгээр өөрчлөн сольж байдаг.

Орчин үеийн барууны соёл нь нэлээд динамик шинжтэй соёл юм. Энэ нь одоо байгаагаас илүү төгс төгөлдөр ирээдүйг хүсэмжилж буй хүлээлттэй холбоотой байх ба үүнтэй холбоотойгоор нийгмийн тогтвортой бус байдал үүсдэг. Уламжлалт нийгэмд уламжлалаа дагах нь өөрөө тогтвортой байдлыг бий болгодог байна. Статист нийгэм уламжлалаасаа хөндийрөх, тасрах нь улс, үндэстэн бүхэлдээ стресс, бухимдалд автах зэрэг нэлээдгүй сөрөг үр дагаврыг бий болгодог гэж үздэг байна.

Зүүн Азийн (Япон, Хятад, Солонгос, Тайланд зэрэг) зарим улс орнуудад ёс суртахууны боловсролыг хүүхэд, залууст олгохдоо ёс суртахууны үнэт зүйлс, нийгэмд ач тус болох, эрдэм мэдлэг, гэр бүлийн харьцаа, соёлын уламжлал зэргийг чухалчлан онцолсон Күнзийн гүн ухаан, уламжлалд тулгуурлан олгодог. Солонгост ёс суртахууны боловсролыг бага ангиас эхлэн тусдаа хичээлээр заадаг ба энэ нь эхэндээ нэлээдгүй маргаан дагуулж байсан бол өдгөө солонгосын нийгмийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан гэж үзэх нь элбэг. Энэ төрлийн хичээл нь өөрийгөө нийгмийн нэг хэсэг болохыг ухаарах, “national identity” үндэсний амин чанар, эх оронч үзэл зэргийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулдаг байна. Японы сургуулиудад мөн ёс зүйн хичээл орох ба тус хичээлийн үндсэн 6 зорилгын нэг нь тухайн сурагч Япон орны үнэт зүйлийг таньж ойлгох, улмаар өөрийн орны соёл, уламжлалыг хадгалах, үнэт зүйлээ өвлүүлэн авч явах иргэнийг төлөвшүүлэх юм. Гэр бүл болон сургууль хоёр хослон нийтлэг үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд оролцдог нь тухайн бүс нутгийн ёс суртахууны боловсролын нэг онцлог болдог байна.

Дорнын боловсролын нэг гол ялгаа нь сургууль дахь ёс суртахууны боловсрол нь гэр бүлийн үргэлжлэл буюу ихэнх сургууль, хүүхдийн гэр бүл нийтлэг үндсэн дээр суурилсантай холбоотой. Иймд сургуульд ёс суртахууны боловсролыг холбогдох хөтөлбөрийн хүрээнд олгосон ч гэр бүлд мөн адил ёс суртахууны ойлголт, ухагдахуун байхгүй, гэр бүл, эцэг эхийн оролцоогүй бол төдийлөн үр дүнд хүрч чаддаггүй гэж үзэх нь элбэг. Учир нь гэр бүл буюу хүүхдийн ахуй орчин хүний ёс суртахууны төлөвшлийн анхан шат гэж үздэгтэй холбоотой байна. Хэдийгээр өндөр ёс суртахуунтай нийгмийг цогцлоон бүрдүүлэхэд гэр бүл, гэр бүлийн үнэт зүйлс чухал ч, сургуульд мөн ёс суртахуун, ёс зүйн боловсрол олгох шаардлага өндөр ба сургуульд олгож буй ёс суртахууны боловсрол нь гэр бүлд олж авсан ёс зүй, ёс суртахууны үндэс, мэдлэгээ “нийгэмшүүлэх”, олж авсан боловсролоо эхний байдлаар сургуульдаа, дараагаар нийгэмдээ хэрэглэж хэвшинэ гэх утгыг агуулдаг. Ёс суртахууны үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд “хиймэл” аргаар хичээл дээр судлах, зааварчилгаа хэлбэрээр олгох нь төдийлөн үр дүн муутай ба ёс суртахууныг төлөвшүүлэхэд хүүхэд гэр бүлийн орчинд олж авсан ёс суртахууны ухагдахууныг гэр бүлээс гаднах орчинд дэлгэрүүлэх байгалийн буюу хиймэл бус шилжилт шаардлагатай гэж үздэг байна. Энэ нь ёс суртахууны боловсрол олгох тал дээр гэр бүл ба сургууль хоёрын хооронд зарчмын ялгаа байх ёсгүй ба дээрх хоёр нь нэг үндэс, үүнд улс орны өөрийн соёлын уламжлал, онцлог зэрэгт суурилсан байхыг чухалчлан үздэг байна.

## **1. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭНД ЁС СУРТАХУУН, ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ ОЛГОДОГ ТУРШЛАГА**

### **1.1. Европын зарим улс орнуудын ёс суртахууны боловсрол олгож буй туршлага**

Улс орнуудын хувьд ёс суртахуун, зан суртахууны боловсрол нь тухайн нийгэм, соёлын онцлог, хэрэгцээ шаардлагаас хамааран юунд ач холбогдол өгч, юуг чухалчилж байгаагаар ялгаатай байх ба хичээлийн хөтөлбөрт хэрхэн тусгаж буй байдлын хувьд мөн харилцан адилгүй байна. Судалгаанд хамрагдсан Европын зарим орнуудын ёс суртахуун, зан байдлын боловсролыг сургуулийн хөтөлбөрт хэрхэн тусгасан (заавал судлах, эсхүл сонгон судлах, бие даасан хичээлийн хүрээнд, эсхүл өөр бусад хичээлийн сэдвийн хүрээнд зэрэг) болон шашин судлалын хичээл ордог эсэх зэргийг харьцуулан Хүснэгт 1-т харуулсан болно.

Ёс зүй, зан суртахууны боловсролын хөгжлийн чиг хандлага, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг бүс нутгийн хүрээнд авч үзвэл, дараах байдалтай байна:

- а) Скандинавын орнууд - зан суртахууны боловсролд нэгдмэл, нийтлэг хандлага давамгайлсан (Дани, Финланд, Норвег, Швед);
- б) Баруун Европ - бүс нутгийн хэмжээнд олон загвар, хандлага бүрэлдэн тогтсон (Франц, Герман, Швейцар, Их Британи, Бельги, Люксембург, Нидерланд зэрэг);
- в) Баруун-Өмнөд болон Өмнөд Европ - шашны боловсрол давамгайлах байр суурийг эзэлсэн (Кипр, Итали, Мальта, Португал, Испани);
- д) Төв Европ болон Балтийн орнууд (Австриас бусад) - (пост-социалист орнууд) шашингүй үзэлд суурилсан ёс суртахууны боловсролын загвартай (Чех, Эстони, Унгар, Латви, Литва, Польш, Словак, Словени);
- е) Европын хөгжиж буй болон Европын Холбооны шинэ гишүүн орнууд – зан суртахууны боловсролыг харьцангуй сүүлд хэрэгжүүлж эхэлж буй орнууд (Болгар, Румын, Серб, ОХУ).

Судалгаанд хамрагдсан Европын 31 улсаас 14 улс ёс суртахуун, зан суртахуунд чиглэсэн сургалтыг бие даасан хичээлийн хүрээнд судалдаг байна. Ингэхдээ дээрх хичээл сонгон судлах хичээлийн тоонд багтах бол шашин судлалын хичээл мөн сонгон судлах хичээлийн тоонд багтах нь түгээмэл байна. Практикт энэ нь хүүхдээ шашны сургалтад хамруулах сонирхолгүй эцэг эхчүүд шашин судлалын хичээлийн оронд шашин болон аливаа идеологиос ангид ёс суртахуун, ёс зүй, зан суртахууны боловсролын хичээлийг сонгох боломжоор хангаж өгдөг байна. 17 улс нь ёс суртахуун, ёс зүй, зан суртахууны боловсролыг бие даасан хичээлийн хүрээнд бус харин бусад хичээлийн судлах сэдвийн хүрээнд олгодог байна. Ингэхдээ хүүхэд, сурагчдын ёс суртахууны боловсролыг бусад хичээлийн (нийгэм судлал зэрэг) хүрээнд олгодог, эсхүл сургалтын агуулга нь бүхэлдээ сурагчдын ёс суртахууныг хөгжүүлэхэд чиглэсэн байх ба сэтгэл судлал, эсхүл гүн ухаан зэрэг хичээл нэмэгдэн ордог гэх 2

хэлбэр түгээмэл тархсан байна. Судалгаанд хамрагдсан орнуудын гуравны нэг нь зан суртахууны боловсролыг орлох/дүйцэх нэг хичээлийн сэдвийн хүрээнд судалдаг байна. Үүнд: Франц, Грек, Унгар, Серби, Словени, Испани, Австри болон Швейцарын зарим мужууд орж байна. Өөр нэгэн хосолсон загвар нь ёс зүйг шашин судлалын хичээл, эсхүл гүн ухааны хичээлтэй хослуулан *non-confessional* шашны хичээл дээр судлах юм.

Хүснэгт 1. Европ дахь ёс суртахуун/ёс зүй, зан суртахууны боловсрол

Улс	Ёс суртахуун/ёс зүй, зан суртахууны боловсрол			Шашны боловсрол	Зан суртахууны боловсролд хамаарал бүхий/ дүйцэхүйц соёл хоорондын бусад хичээлүүд
	Бие даасан хичээлийн хүрээнд судалдаг	Зан суртахууны боловсролд чиглэсэн сэдвийг бусад хичээлийн хүрээнд судалдаг	Ёс зүй, зан суртахууны хичээлийн статус: <b>C</b> -Заавал судлах <b>CE</b> заавал судлах/сонгон судлах <b>O</b> -optional	Conf -confessional  NConf - non-confessional. <sup>52</sup>	
1. Австри	Ёс зүй,  <i>SoKeBeWe</i> (education toward social competences and ethically reasoned value attitudes)	Вена: <b>CE - KER</b> (Studies of Culture, Ethics and Religions),  <b>AKG</b> (Anthropology and Cultural Studies)	CE	C/CE - Conf (possibility of withdrawal)	Түүх, нийгэм судлал ба иргэншил, заавал судлах сэтгэл судлал ба гүн ухааны хичээл  (ISCED 3)
2. Бельги	Ёс зүй		CE	CE - Conf	Social behaviour, social skills
3. Болгар	Ёс зүй		C	O - Conf	Humans and society, Social studies and Citizenship
4. Кипр	-		-	C - Conf	Moral education
5. Чех	Зан суртахууны боловсрол		O	O - Conf	Humans and their environment, Personal and social education  Drama education
6. Дани	-	C – Studies of Christianity (integration of religion, philosophy of life and ethics)		C - NConf (integrated with ethics and philosophy as Studies of Christianity)	Social studies, Personal and social development, education towards democracy
7. Эстони	-		-	O - NConf	Citizenship
8. Финланд	Ёс зүй		CE	CE - Conf	

<sup>52</sup>Conf.-confessional-Шашны нэг гол урсгалд чиглэх ба сургалтын хөтөлбөр (хичээлийн агуулга, сургалтын материал) боловсруулахад шашны нийгэмлэгүүд голлох үүргийг гүйцэтгэнэ. Nconf.-non-confessional-аль нэг шашны урсгалд чиглэхгүй, шашны талаарх ойлголтыг ерөнхий хүрээнд олгох ба төр (сургуулиуд) нь төвийг сахисан байр сууринаас, хүний шашин шүтэс, эс шүтэх эрх чөлөөг хүндэтгэж, сургалтыг явуулна.

9. Франц	-	C – Civics and Moral Education		-  (with the exception of Alsace and Lorraine CE - Conf)	Autonomy and initiative,  Citizenship, legislative and social education
10. Герман	Ёс зүй / philosophy Life formation – Ethics/ Religious Studies Philosophising with children, values and norms, Humanistic Character Education		CE  O	C, CE - Conf  O - Conf  C - NConf	
11. Грек	-	C - Social Studies and Citizenship		C - Conf	Environmental studies, Social Studies and Citizenship
12. Унгар	-	C - Studies of Society, Studies of Humans and Ethics		O - Conf	Humans and society
13. Итали	-	-	-	O - Conf	Planned alternative Citizenship and Human Rights
14. Ирланд	-		-	C - Conf	Social, personal and health education
15. Латви	Ёс зүй		O (substitution of R.E.)	O - Conf.	Studies of ethics and religion, History of religions
16. Литва	Ёс зүй		CE	CE - Conf	Development of moral awareness
17. Люксембург	Ёс суртахуун ба нийгмийн боловсрол		CE	CE - Conf	
18. Мальта	-		-	C - Conf	Social studies, Personal and social education
19. Нидерланд	Humanistic Ethics and Worldview Education		O	O - Conf  C - NConf  (integrated in Social studies)	Social studies, Personal and social education, including citizenship  Humans and society  Humans and nature

20. Норвег		C - Religion, Philosophy and Ethics <i>Religion, livssyn og etik (RLE)</i>		C - NConf (included in RLE)	Social studies, Religionistics and Ethics
21. Польш	Ёс зүй		CE	CE - Conf	History and Citizenship education
22. Португал	-		-	O - Conf (Moral and Religious Education)	Personal and social education, Citizenship
23. Румын	-		-	O - Conf	Human life and society (citizenship)
24. ОХУ	Зан суртахууны боловсрол		O (alternative of R. E. since 2010)	O- Conf (comparing Islam, Christianity, Judaism, Buddhism,)	Natural, Social and Cultural Environment, Social Studies (specific topics: Humans and society, Spiritual life)
25. Серби	-	CE - Citizenship		CE - Conf	
26. Словак	Зан суртахууны боловсрол		CE	CE - Conf	Humans and values, Personal and social education, Multicultural and medial education
27. Словени	-	O - Ethics and Religion (ER), C - Citizenship and Ethics		O - NConf (integrated with Ethics in ER)	Citizenship, Social sciences
28. Испани	-	C - Ethical and Citizenship Education (in 4 <sup>th</sup> grade ISCED 2)	-	O - Conf	Citizenship and Human Rights Education Social studies
29. Швейцар	Ёс зүй (зарим кантонд Шашны хичээлийг орлоно)	C - Ethics and Religions (in cantons: Aargau, Luzern, Nidwalden, Obwalden, Thurgau, Uri, Zug)	CE (alternative of R.E.)	C - NConf (in cantons with Ethics and religion, or Religion and culture, in others CE - Conf.	Citizenship
30. Швед	-	C - Social Studies (including ethics and religion)	-	C - NConf (included in Social studies); also O - Conf	Social Studies (Ethics, Religion, Geography and History), Citizenship



31. ИБУИНВУ:	-	-		a), b) C - NConf	a), b) Personal, social and Health education, citizenship;
a) Англи				c) Religious and moral education - CE predominantly Conf	c) Personal and Social Development, Citizenship;
b) Уэльс				- Christian	d) Personal development +mutual understanding, Personal and social education
c) Шотланд				d) C - Conf	
d) Умард Ирланд					

Улс орон бүрийн ёс суртахуун /ёс зүй/ ба зан суртахууны боловсролын сургалт нь ёс суртахууны ухамсрыг дээшлүүлэх, сурагчдад иргэн бүр мэдэж байвал зохих улс төрийн тогтолцоо, эдийн засаг, нийгмийн асуудлуудын тухай мэдлэг, ойлголтыг өгөх зорилготой байдаг. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Итали, Франц, Бельги, Финланд, Норвег, Эстони зэрэг Европын зарим улсын ерөнхий боловсролын сургуульд ёс суртахууны болон иргэний боловсролын хичээлийг хэрхэн явуулж буй талаар товч дурдвал дараах байдалтай байна.

**ХБНГУ:** Дунд болон их сургуулиудын Иргэний боловсролын хичээлийн үндсэн зарчмыг 1950 оны 6 дугаар сарын 15-нд Боловсролын Ландер сайд нарын хуралдаанаас тогтоосон байна. Тэр нь: “Иргэний боловсрол нь сурагчдын ёс суртахууны ба нийгмийн хариуцлагатай гишүүний үйл үйлдлийн ухамсрыг төрүүлэх ёстой” гэжээ.

**ИТАЛИ:** Боловсролын яамнаас эрхлэн хэвлүүлсэн бага сургуулийн хичээлийн хөтөлбөрт иргэний боловсрол хичээлээр “хүүхдэд ерөнхий ёс суртахуун, шашны болон нийгмийн сургалтыг олгоход” чиглэнэ гэжээ. Мөн “шашны хичээлээр хүүхдэд ёс суртахуун, иргэний болон нийгмийн зан үйлдлийн, бас гэр орон, сургууль ба нийгэмдээ эрүүл ахуйтай байх үндсэн зан чанарыг бүрэлдүүлнэ. Мөн хүүхдэд хувийн хариуцлага ба бүлгийн гишүүн гэх ухамсрыг төрүүлнэ” гэсэн байна. Харин бусад дээд ангийн сурагчдын иргэний боловсролын хичээлийн тухайд, “Эх орноо хайрлах сэтгэл нь гэр бүлээ хайрлах төрөлх сэтгэлээс үүдэн хөгжсөн байх, үндэстний үнэт зүйлсийн тухай ухамсар нь олон улсын өв тэгш ойлголттой уялдсан байх ёстой” гэжээ.

**ФРАНЦ:** Тус улсын Боловсролын яамнаас 1923 онд хэвлүүлсэн суурь боловсролын хичээлийн хуваарьт “ёс суртахууны боловсрол нь хүүхдийг сэтгэл хөдлөл, оюун ухаан ба итгэл үнэмшлийн тэнцвэртэй хөгжил бүхий хүн болж, өсөж хүмүүжихэд туслах ёстойг”, мөн “ёс суртахууны сургаал зааварчилгаа нь хүүхдэд зөвхөн нэг ёс суртахууны сэтгэлгээг төрүүлээд зогсохгүй бас энэхүү оюун санааг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэхэд хөтлөн жолоодох ёстой” хэмээн өгүүлсэн байна.

Францын бага сургуулиудад “civique et morale” хэмээх боловсролын хичээлийг дараах байдлаар заадаг байна. Үүнд:

1 дүгээр анги - Ихэвчлэн багш нарынхаа ярих үлгэрүүд (Жан Лафонтен болон Ганс Христиан Андерсоны үлгэрүүд) ба агуу хүмүүсийн намтрыг сонсох.

2-3 дугаар ангид - Ярилцлага болон ном зохиол унших арга хэлбэрээр сайн зан үйлд суралцахад нь хүүхдүүдийг дасал болгох. Гуравдугаар ангид хоёрдугаар ангид үздэгтэй ижил сэдвүүдийг илүү гүнзгийрүүлэн судална.

4-5 дугаар ангид - Хувь хүмүүсийн үйл хэрэг болон нийгмийн ёс суртахууны талаар тэвчээр, хүндэтгэл, эелдэг зан, эр зориг, өгөөмөр зан зэрэгтэй уялдуулсан өгүүллэг зохиол сонсох, эсхүл ярилцах.

Мөн хүүхдэд хөдөлмөрийн үнэ цэнийн тухай ойлголт, бусадтай хамтран ажиллах сайхан сэтгэл, амлалтаа биелүүлэх чанар, бусдыг ойлгох, гэр бүл болон улс нийгэмдээ хүлээх үүргээ ухамсарлах зэргийг сургах.

5 дугаар ангид - 4 дүгээр ангийнхтай адил сэдвээр боловч илүү гүнзгий судална.

6-8 дугаар ангид - Хүүхдийн ухамсарт хүнийг хүндэтгэх сэтгэл төрүүлэх, зөв зан чанарыг бүрэлдүүлэх, хувийн болон гэр бүл, улс нийгэмдээ хүлээх үүрэг хариуцлагыг ойлгуулах, эх оронч, үнэнч шударга, харилцан туслалцах, хөдөлмөрийг хүндэтгэх, Засгийн газрын бүтэц, үйл ажиллагаа, гэрээ ба өдөр тутмын амьдрал дахь хөдөлмөрийн хуулийн тухай үндсэн мэдлэг, эрх зүй, захиргааны болон шүүхийн тогтолцоо, иргэний эрх ба үүрэг, олон улсын ойлголт зэргийн тухай суурь анхдагч мэдлэгийг олгоно.

**БЕЛЬГИ:** Бельгийн дунд сургуульд (дунд боловсролын 3-4 дүгээр ангиудад, 14-15 насанд) “иргэншил ба эх оронч үзэл”-ийг дараах сэдвүүдийн хүрээнд заадаг байна. Үүнд:

- Иргэний эрх: ардчилсан болон парламентын тогтолцооны давуу тал. Бельгийн Үндсэн хуулиар баталгаажуулсан үндсэн эрх, эрх чөлөөний тухай;
- Иргэний үүрэг: сонгуульд оролцох, хуулийг сахин биелүүлэх, цэргийн алба хаах, татвар төлөх, шүүхэд гэрчийн мэдүүлэг өгөх;
- Эх оронч үзэл: эх орны нэр хүнд ба өв уламжлал, буруу эх оронч үзлийн аюул;
- Олон улсын тухай ойлголт: хүн төрөлхтний ахан дүүсийн ёсон, Европын улс орнуудын Иргэний боловсрол олгох арга хэлбэр зэрэг болно.

Нэлээдгүй улс оронд эдгээр хичээлд зориулсан тус тусын сурах бичгүүдийг хэрэглэхээс гадна аудио бичлэг, слайд, кино, радиогийн нэвтрүүлэг, телевиз гэх зэрэг туслах хэрэгсэл, сургалтын материалуудыг ашигладаг байна.<sup>53</sup>

<sup>53</sup>Moral education other countries- [http://www.mext.go.jp/b\\_menu/hakusho/html/hpae196501/hpae196501\\_2\\_032.html](http://www.mext.go.jp/b_menu/hakusho/html/hpae196501/hpae196501_2_032.html)

**ФИНЛАНД:** Ерөнхий боловсролын асуудал эрхэлсэн Боловсролын үндэсний зөвлөлөөс үндэсний хэмжээнд мөрдөх үндсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулдаг ба энэхүү хөтөлбөрт хичээлийн сэдвүүдийн ерөнхий агуулга болон зорилтуудыг тусгасан байдаг. Үндсэн сургалтын хөтөлбөрийн дагуу муж бүр сургалтын хөтөлбөрөө боловсруулна, мужийн сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сургууль бүр сургалтын хөтөлбөрөө боловсруулж мөрддөг.

Суурь боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлд Боловсролын агуулгыг дараах байдлаар томъёолсон байна.<sup>54</sup>

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр нь 14-р зүйлд заасны дагуу батлагдсан байх ба, үүнд дараах гол хичээлүүд багтана: эх хэл, уран зохиол, хоёр дахь (фин/швед) эх хэл, гадаад хэл, хүрээлэн буй орчны судалгаа, эрүүл мэндийн боловсрол, шашны боловсрол болон ёс зүй, түүх, нийгмийн ухаан, математик, физик, хими, биологи, газар зүй, биеийн тамир, хөгжим, дүрслэх урлаг, гар урлал мөн өрхийн эдийн засаг зэрэг хичээлүүд.

Дээрх хуулийн зохицуулалтын дагуу Засгийн газраас нийтлэг сэдвийн хүрээнд тухайн жилийн 7 хоногт үзэх хичээл, цагийн хуваарийг баталдаг. Энэ хуваарь нь жишиг хуваарь бөгөөд Үндэсний сургалтын хөтөлбөрт нийцүүлэн муж болон сургуулиуд хичээл, цагийн хуваариа өөрсдөө батлах эрхтэй байдаг.

Хүснэгт 2. Бага, дунд ангид судлах хичээлийн цаг<sup>55</sup> (7 хоногт үзэх хичээлийн цаг)

ХИЧЭЭЛИЙН НЭР	АНГИ									Нийт цаг
	1	2	3	4	5	6	7	8	9	
Эх хэл, уран зохиол	14			18				10		42
Гадаад хэл				9				7		16
2 дахь албан ёсны хэл						2		4		6
Математик	6			15				11		32
Байгаль орчин	4			10						
Биологи, газар зүй								7		
Физик, хими								7		
Эрүүл мэнд								3		
Байгаль орчин, байгалийн судалгаа				14				17		31
Шашин, ёс зүй	2			5				3		10
Түүх, нийгэм				5				7		12
Хөгжим	2			4				2		8
Дүрслэх урлаг	2			5				2		9
Гар урлал	4			5				2		11
Биеийн тамир	4			9				7		20
Өрхийн эдийн засаг								3		3
Урлаг болон сонгон судлах хичээл сонгоход				6				5		11

<sup>54</sup>Финландын Суурь боловсролын тухай хууль <https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1998/en19980628.pdf>

<sup>55</sup>Засгийн газрын торгоол, 2012.06.28 [http://www.oph.fi/download/179422\\_distribution\\_of\\_lesson\\_hours\\_in\\_basic\\_education\\_2012.pdf](http://www.oph.fi/download/179422_distribution_of_lesson_hours_in_basic_education_2012.pdf)

Урлаг болон сонгон судалсан хичээлд нийтдээ			62
Зөвлөгөө өгөх		2	2
Нэмэлт сэдэв		9	9
Нэмэлтээр гадаад хэл		12	12
Нэмэлтээр 2 дахь эх хэл		4	4
Нийт хамгийн багадаа судалбал зохих цаг			222

**НОРВЕГ:** нь ерөнхий стандартад суурилсан сургуулийн нэг тогтолцоотой. Засгийн газрын тогтоосон сургалтын стандартыг хянахын тулд улсын сургалтын хөтөлбөрийг боловсруулан, мөрддөг байна. Заавал эзэмших боловсролын хөтөлбөрийн дагуу арван жилийн боловсрол эзэмших бөгөөд үүнд бага, бүрэн бус дунд, бүрэн дунд сургуулиуд багтана. Боловсролын байгууллагуудын үүрэг нь бүхий л хот, бүс нутагт хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд тохирох боловсролоор хангах явдал байна. Орон нутгийн засаг захиргаа нь бага болон дунд сургуулиудын үйл ажиллагааг хариуцдаг бол бүрэн дунд сургуулийн удирдлага, зохион байгуулалтыг бүс нутгийн түвшинд хариуцна. Норвегид ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгох ба үүнд бүрэн дунд боловсрол орно. Бие даасан хувийн сургуулиуд нь нэмэлт боловсрол олгодог.

Суурь боловсрол буюу 1-ээс 10-р анги нь үнэ төлбөргүй байна. Жилд 38 долоо хоног хичээллэдэг. Бага сургуульд долоо хоногт 20 цагийн хичээл судална. Математик - 4 цаг, норвег хэл - 6 цаг, байгалийн судлал - 1 цаг, англи хэл - 1 цаг, зураг, хөдөлмөр, биеийн тамир, дуу хөгжим тус бүр - 1-2 цаг, шашин судлал - 2 цаг. Шашны хичээл нь Норвегийн сургуулиуд нь 250 жилийн өмнөөс сүм хийдийг даган байгуулагдаж байсантай холбоотой ба өдгөө библи судлах/шашин судлах нь түүх судлахтай адил гэж тооцдог байна.

Норвегийн улсын ерөнхий боловсролын сургуулиуд дахь шашны боловсрол нь нэлээдгүй маргаан дагуулдаг. Тус улс нь Швед, Их Британийн адилаар бүх сурагчдад, тэдгээрийн шашин шүтлэгээс үл хамааран шашны судлалын хичээл ордог. Христийн шашин, шашин судлал ба ёс зүйн хичээл (KRLE) 1997 онд батлагдсанаасаа хойш нэлээдгүй шүүмжлэл дагуулж, улмаар хичээлийн агуулгад хэд хэдэн удаа өөрчлөлт оруулсан. 2006 онд Европын Хүний эрхийн шүүхээс KRLE нь христийн шашинд давуу байдал олгосон гэх шүүхийн шийдвэр гаргасан байна.<sup>56</sup>

<sup>56</sup><http://religiongoingpublic.com/archive/2016/religious-education-in-norway-distance-and-unease>

Хүснэгт 3. Шашин судлал хичээлийн агуулга (1997 он)

Судлах зүйл	Анхан шат 1-4 түвшин	Анхан шат 5-7 түвшин	Дунд шат 8-10 түвшин
<b>Библи судлах</b>	Библийн үндсэн өгүүллэгүүд	Библийн өгүүллэгүүд	Библийн төрлүүд, Библи – ариун судар, библийн түүх
<b>Христийн шашны түүх</b>	Христийн шашны түүхээс	Христийн шашны үүссэн түүх: хөгжил, хүмүүс, соёлын илэрхийлэл	Христийн шашны орчин үеийн түүх: хөгжил, хүмүүс, соёлын илэрхийлэл
<b>Христийн шашин орчин үед</b>	Христийн шашинтны баярууд, шашны бэлгэдлүүд, өдөр тутмын амьдрал дахь шашин	Христийн итгэл үнэмшил ба ёс зүй	Христийн шашны урсгалууд, ижил болон ялгаатай талууд
<b>Бусад шашин</b>	Бусад шашнууд ба амьдралыг үзэх үзэл, түүх болон баяр наадмууд	Ислам, Жүүд, Хиндү, Буддын шашин, тэдгээрийн амьдралыг үзэх үзэл	Орчин үе ба шашин/ орчин цагийн шашин шүтлэг
<b>Ёс зүй/ философи</b>	Ёс зүйн талаарх ойлголт: миний ба чинийх, би ба бусад	Ёс зүйн талаарх ойлголт: үнэт зүйлс ба сонголтууд	Хүн төрөлхтөний философийн тайлбар, үнэт зүйл ба хэм хэмжээ

## 1.2. Ази, номхон далайн зарим улс орнуудын ёс суртахууны боловсрол олгож буй туршлага

**ЯПОН:** Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, амьдрах орчин, хөгжим, зураг, гар урлал, биеийн тамир, гэрийн аж ахуй гэсэн хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр ёс суртахууны хичээл ордог.

Дунд ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, хөгжим, зураг, биеийн тамир, үйлдвэрлэлийн урлаг, гэрийн аж ахуй, гадаад хэл, сонгон судлах хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр ёс суртахууны хичээл орно.<sup>57</sup>

1890 онд Эзэн хаан Боловсролын тухай зарлиг гаргасан ба энэхүү зарлигаар зайлшгүй эзэмших шинэ боловсролын тогтолцооны өөрчлөлтөд Японы үнэт зүйлийг гол болгон баримтална гэж тунхагласан байна. Энэ нь үнэнч зүтгэл, ахмадын хүндлэл, гэр бүлийн гишүүд, хань ижил, анд нөхөдтэй тогтоосон харилцаа зэрэг ёс суртахууны чанаруудыг чухалчлахыг сануулсан зарлиг байсан юм.

Японы суурь боловсролын тухай хуулиар ёс суртахуун, ёс зүйн боловсролыг заавал эзэмшүүлэх албан боловсрол гэж заасан ба энэ нь Японы үндэсний өв, соёлтой салшгүй холбоотой юм.

<sup>57</sup><https://www.nuffic.nl/en/publications/find-a-publication/education-system-japan.pdf>

Ёс зүйн боловсрол нь тухайн сурагч Япон орны үнэт зүйлийг таньж ойлгох, улмаар өөрийн орны соёл, уламжлалыг хадгалах, үнэт зүйлээ өвлүүлэн авч явах иргэнийг төлөвшүүлэх зорилготой юм. Иймд ерөнхий боловсролын сургуульд ёс зүй, ёс суртахууны боловсрол олгоход маш их анхаардаг байна.

Ерөнхий боловсролын сургуульд ёс суртахууны хичээлийг дараах 4 төрлийн агуулгад тулгуурлан заадаг.<sup>58</sup>

1. Өөрийнхөө тухай: Хүн бүр бие даасан байх, өөрсдийн хийж чадах зүйлээ хийх, хэм хэмжээтэй амьдрах;
2. Бусад хүмүүстэй харилцах харилцаа: Хүмүүстэй шударга харилцах, хүмүүстэй эелдэг харилцах;
3. Байгаль, эрхэм дээд зүйлтэй харилцах: Байгалийн гамшиг, байгаль, амьтны ач холбогдлыг мэдрэх;
4. Нийгэм болон бүлгүүдийн тухай: Олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, дүрэм журмаа дагах, амлалтаа биелүүлэх.

Хүснэгт 4. Бага болон дунд ангид судлах хичээлийн цаг<sup>59</sup>

ХИЧЭЭЛИЙН ТӨРӨЛ	АНГИ								
	1	2	3	4	5	6	7	8	9
Япон хэл	272	280	235	235	180	175	140	140	105
Нийгэм судлал	-	-	70	85	90	100	105	105	140
Тоо бодлого	114	155	150	150	150	150	-	-	-
Математик	-	-	-	-	-	-	140	105	140
Шинжлэх ухаан	-	-	70	90	95	95	105	140	140
Амьдрах орчин	102	105	-	-	-	-	-	-	-
Хөгжим	68	70	60	60	50	50	45	35	35
Зураг, гар урлал	68	70	60	60	50	50	-	-	-
Өрхийн эдийн засаг	-	-	-	-	60	55	-	-	-
Биеийн тамир	90	90	90	90	90	90	-	-	-
Уран зураг	-	-	-	-	-	-	45	35	35
Эрүүл мэнд, биеийн тамир	-	-	-	-	-	-	105	105	105
Үйлдвэрлэлийн урлаг, гэрийн урлаг	-	-	-	-	-	-	70	70	35
Гадаад хэл	-	-	-	-	-	-	140	140	140
Ёс суртахуун	34	35	35	35	35	35	35	35	35
Дүгнэлт хичээл	-	-	105	105	110	110	50	70	70
Сонгон судлах хичээл	34	35	35	35	35	35	35	35	35
<b>НИЙТ /ЖИЛД/</b>	<b>782</b>	<b>840</b>	<b>910</b>	<b>945</b>	<b>945</b>	<b>945</b>	<b>1015</b>	<b>1015</b>	<b>1015</b>

**ШИНЭ ЗЕЛАНД:** Тус улс нь боловсролын салбартаа ихээхэн анхаарал хандуулан ач холбогдол өгдөг ба нэг сурагчид ногдох зардлын хэмжээгээр ЭЗХАХБ-ын дунджаас доогуур байгаа ч боловсролын салбарт зарцуулж буй төсвийн зарцуулалтын (13,2%) хэмжээгээр дэлхийд дээгүүр байр эзэлдэг.<sup>60</sup>

<sup>58</sup>Moral education in Japan <https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303MED.pdf>

<sup>59</sup>Moral education in Japan <https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303MED.pdf>

<sup>60</sup><https://data.oecd.org/eduresource/public-spending-on-education.htm>



Шинэ Зеланд нь 6-16 насны бүх хүүхдэд заавал эзэмших суурь боловсрол олгох ч ихэнх хүүхдүүд 5 наснаас сургуульд хамрагддаг байна. 5-19 насанд олгох боловсролыг үнэ төлбөргүй олгоно. Сургуулиуд нь улсын, шашны болон хувийн гэсэн 3 төрөлтэй. Улсын сургуулиуд нь үнэ төлбөргүй байх ба хүүхдүүд харьяаллын дагуу хамгийн ойр байрлах сургуульд хамрагдана. Энэ төрлийн сургууль нь үнэ төлбөргүй байх боловч сурах бичиг, дүрэмт хувцас, сургуулийн хэрэглэл зэргийг сурагчийн эцэг, эх хариуцна. Шашны сургалттай улсын сургууль (гол төлөв Католик сургууль) нь үнэ төлбөргүй байх, дээрхтэй адил зарим зардлыг сурагчийн эцэг, эх хариуцна. Хувийн сургуулиуд нь шашны боловсрол, гүнзгийрүүлсэн сургалт зэргийг олгож болно.

Бага боловсролыг 5-аас дээш насны хүүхдэд олгож болох ч заавал эзэмших боловсролыг 6-16 насанд олгоно. Сургалтын үндэсний хөтөлбөр 1-10-р ангийг багтаах ба 1-8 анги нь бага боловсрол, 9-10 анги нь бага дунд боловсрол 11-13-р анги нь бүрэн дунд боловсрол олгоно. 11-13-р анги нь заавал эзэмших боловсролд хамаарахгүй боловч дээд боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардлагатай. Гадаад хэлийг 1-р ангиас эхлэн заана. (Common European Framework for Languages, Global Scale Level A1: Basic User; Council of Europe, 2001)

Сургалтын үндэсний хөтөлбөрийн хүрээнд дараах хичээлийг судална:

- англи хэл; урлаг; эрүүл мэнд ба биеийн тамир; гадаад хэл; математик; шинжлэх ухаан; нийгмийн ухаан; технологи.

**БНСУ:** Бага сургуулийн сургалтын хөтөлбөрт үндсэн хичээлүүд болох ёс зүй/ёс суртахуун<sup>61</sup>, эх хэл, гадаад хэл, математик, шинжлэх ухаан, нийгмийн ухаан, биеийн тамир, дуу хөгжим болон урлагийн хичээлүүд ордог байна. Жилд 34 гаруй долоо хоногийн хичээл орох бөгөөд, бага ангийн 1-2 дугаар ангид 850 цаг, 3-4 дүгээр ангид 986 цаг, 5-6 дугаар ангид 1088 цагийн хичээл тус тус үздэг байна.

Сургалтын хөтөлбөрийг боловсролын нийгэмд гарч буй өөрчлөлтүүдтэй уялдан гарсан хэрэгцээ, шаардлага, шинээр гарч ирж буй мэдлэгийн салбар зэрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулах бөгөөд БНСУ-ын хувьд сургалтын хөтөлбөрөө нийт 7 удаа шинэчилсэн байна. 7 дугаар буюу хамгийн сүүлийн шинэчлэлийг 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталсан бөгөөд бага, дунд сургуульд 2000 оноос нэвтрүүлж эхэлсэн байна. Тус хөтөлбөрийг даяаршил болон мэдээлэлд суурилсан нийгмийн шаардлагад нийцүүлэхийг зорьсон ба уламжлалт сургалтын арга барил буюу мэдлэг, мэдээллийг “халбагадаж” олгодгоос бие даан суралцах, сурагч тус бүрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон хэлбэрийг нэвтрүүлэх, өргөжүүлэх, хичээлийн ачааллыг бууруулах тал дээр анхаарсан байна.

<sup>61</sup>ethics/moral education

Шинэ хөтөлбөрийн хүрээнд бага сургуулийн 1 дүгээр ангиас ахлах сургуулийн 1 дүгээр анги (1-10-р анги)-н үндсэн хөтөлбөрөөр хичээллэх бол ахлах сургуулийн 2-3 дугаар анги (11-12-р анги)-д сурагчид өөрсдийн ирээдүйн зорилго, зорилтод нийцүүлэн сурах хичээлүүдээ сонгон суралцах юм.

Хүснэгт 5. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилд үзэх хичээлийн цаг

Хичээл		Бага сургууль						Дунд сургууль			Ахлах сургууль			
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Сургалтын хөтөлбөр	Эх хэл Урлаг	Эх хэл Урлаг	Эх хэл Урлаг	238	204	204	204	170	136	136	136	Сонгон судлах хичээл		
	Ёс зүй	210	238	34	34	34	34	68	68	34	34			
	Нийгмийн ухаан	Математик 120	Математик 136	102	102	102	102	102	102	136	170 (Түүх 68)			
	Математик	Ёс зүй 60	Ёс зүй 68	136	136	136	136	136	136	102	136			
	Шинжлэх ухаан			102	120	102	102	102	136	136	102			
	Практик сургалт	Ухаалаг амьдрал 90	Ухаалаг амьдрал 102	-	-	68	68	Техникийн боловсрол/Хөдөлмөр-гэр ахуй						
	Биеийн тамир	Хөгжилтэй амьдрал 180	Хөгжилтэй амьдрал 204	102	102	102	102	102	102	68	68			
	Дуу хөгжим			68	68	68	68	68	34	34	34			
	Урлаг	Бид 1-р анги 80		68	68	68	68	34	34	68	34			
	Гадаад хэл (Англи)			34	34	68	68	102	102	136	136			
Бие даан суралцах		60	68	68	68	68	68	136	136	136	204			
Тусгай арга хэмжээ		30	34	34	68	68	68	68	68	68	68	8 нэгж		
Жилд үзэх хичээл (Цаг)		830	850	986	986	1,088	1,088	1,156	1,156	1,156	1,156	144 нэгж		

Ёс зүй/ёс суртахууны ухагдахуун нь 1950-иад онд анх сургалтын хөтөлбөрт туссан бөгөөд цаг үе, нийгмийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагатай уялдан хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна.

БНСУ-ын анхны бие даан баталсан Сургуулийн хөтөлбөрт (1955-1963) ёс зүйн боловсрол нь нийгмийн ухааны хичээлийн агуулгад багтаж байсан. Ёс зүйн хичээлийг Боловсролын яамнаас батлагдсан журмын дагуу зааж эхэлсэн бөгөөд ёс зүйн боловсрол нь иргэний боловсролд чиглэж байсан (АНУ-ын “ардчилсан иргэний боловсрол” дээр суурилсан).

- 1973 онд ёс суртахууны хичээл нь сургалтын хөтөлбөрт бие даасан хичээл болж орсон бөгөөд улмаар 1974 онд ахлах сургуульд ёс суртахууны хичээлээр үндэсний ёс зүйг<sup>62</sup> судалж эхэлсэн. Тухайн үед ёс зүйн хичээл социализмын нөлөөг эсэргүүцэх, эдийн засгийг сэргээх, үндэсний уламжлалыг сэргээхэд чиглэгдэж байсан.

<sup>62</sup>national ethics

- 1973-1982 онд ёс зүйн хичээл бага, дунд сургууль болон дээд сургуульд гэсэн гурван үндсэн чиглэлээр орох болсон.
- 1982-1988 онд уг хичээл заах арга бүрэн шинэчлэгдсэн бөгөөд хэлэлцүүлэг хэлбэрээр хичээл заагдах болсон.
- 1989-1994 онд амьдралын ардчилсан байдал илүү тусгагдах болсон.
- 1995-1999 онд хүнлэг байдал, итгэл үнэмшил, ёс зүйн хүмүүжлийн үндсэн төлөвшил олгогдоход чиглэсэн. Энэ үеэс хоёр Солонгос нэгдэл ба Солонгос улс нэгдсэний дараа гэсэн хоёр үеийн амьдралын зорилгыг тусгайлан заах болсон, мөн “national identity” (үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанар)-ын томъёоллыг тусгасан.
- 2000 оноос буюу одоо мөрдөгдөж буй 7 дугаар сургалтын хөтөлбөрт “ethnic identity” (үндэс угсаа) гэх ойлголт их орсон байна. 7-10-р ангийн ёс зүйн хичээлийн сурах бичиг нь 1) хувийн амьдрал, 2) гэр бүл, хөрш, сургууль дахь амьдрал, 3) нийгмийн амьдрал, 4) үндэсний болон хамт олны амьдрал<sup>63</sup> гэх 4 хэсгээс бүрдэж байна. Эдгээрт “national identity” гэж тусгайлан томъёолоогүй ч 8, 10-р ангийн сурах бичгийн 4 дахь хэсэг буюу “үндэсний болон хамт олны амьдрал”-д дээрх ойлголтыг тусгасан байна. Тухайлбал, 8-р ангийн ёс зүйн сурах бичгийн “үндэсний болон хамт олны амьдрал” хэсэг 4 бүлгээс бүрдэж байна. Үүнд:

1. Солонгосын үндэсний хөгжил ба соёлыг эзэмшихүй (*Korean national development and cultural fluency*);
2. Төрийн болон үндэсний хөгжлийн ач холбогдол (*The importance of the state and national development*);
3. Төр, улс үндэстнийг зөв хайрлах (*Correct love of the state and nation*);
4. Нэгдэл ба Хойд болон Өмнөд Солонгосыг нэгтгэх хүч чармайлт (*Unification and strong will for the reunification of the North and South (Korea)*).

7 дахь сургалтын хөтөлбөрт орсон ёс зүйн хичээлийг ерөнхийд нь үзвэл Солонгос үндэс угсаа, хоёр Солонгосын нэгдэл болон даяаршил гэсэн 3 асуудлыг хөндсөн байна. Хэдийгээр эдгээр асуудлууд нь өмнөх сургалтын хөтөлбөрүүдэд багтаж ирсэн хэдий ч шинэ хөтөлбөрт дээрх асуудлуудад харьцангуй их ач холбогдол өгсөн байна.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>63</sup>national and community life

Хүснэгт 6. Ёс зүйн хичээлийн агуулга

Хичээлийн ерөнхий агуулга	3-р анги	4-р анги	5-р анги	6-р анги	7-р анги	8-р анги	9-р анги	10-р анги
“Би” ёс суртахууны субьект болох нь	“Ёс суртахуун”-ыг хэрхэн судлах вэ Миний үнэ цэнэтэй амьдрал	Шударга амьдрал Бие даасан амьдрал	Сэтгэл хөдлөлийн менежмент Амьдралын тусгалууд	Бардамнал ба өөрийгөө хөгжүүлэх Өөрийнхөө зан авирт хариуцлага хүлээх Зоригтой үйлдэл	(Хүн ба ёс суртахуун) Ёс суртахууны ойлголт Ёс суртахууны асуулт, асуудлууд Ёс суртахууны үйлдэл	(Ажиллах, сурах) Ажиллах, зугаацах Сурах, ирээдүйн төлөвлөгөө Төлөвлөгөө ба амжилт	(Амьдралын зорилго) Өөрийгөө танин мэдэх Аз жаргалтай амьдрал	(Хүн ба эрх чөлөө) Эрх чөлөө ба өөрийгөө жолоодох Ёс суртахууны үнэлгээний процесс
Өөр хоорондоо болон нийгмийн харилцаа	Гэр бүлээ хайрлах, биеэ зөв авч явах Талархлаа илэрхийлэх Нөхөрлөл ба найз нөхөдтэйгээ биеэ зөв авч	Амлалдаа эзэн болох Олон нийтийн ёс зүй Интернэт ёс зүй	Хөршүүдтэйгээ, зөв сайн харьцах Бие биедээ туслах Харилцан ярилцах болон зөрчлийг шийдвэрлэх Компьютер тоглоомонд донтохоос сэргийлэх	Хууль, дүрэм журам сахих Ажиллалт Зөв, шударга үйл Бусдад санаа тавьж, ойлголцох	(Хүмүүжил ба ёс суртахуун) Гэр бүл болон ёс суртахуун Найз болон нөхөрлөлийн утга учир, үнэ цэнэ Хөршүүддээ санаа тавих, халамжлах Кибер орчин дахь ёс суртахуун	(Өсвөр үеийнхэн ба ёс суртахуун) Өсвөр үеийнхэн, хүн чанар алдагдах асуудал Асуудлыг энхийн замаар шийдвэрлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх өөр хүйтэнтэй нөхөрлөх	(Хүний нэр төр, хүний эрх) Хүний нэр төр ба цөөнхийн эрхийг хамгаалах Жендэрийн эрх тэгш байдлыг ёс суртахууны ойлголт	(Нийгмийн шударга ёс ба ёс зүй) Нийгмийн институци ба ёс зүй Нийгмийн эрх ёс зүйн асуудлууд

Улс, үндэстэн болон дэлхийн хамтын нийгэмлэг	Улс үндэстний бэлгэ тэмдэг ба улсаа хайрлахуй	Улс болон үндэс угсаагаар бахархах	Хойд Солонгос дахь амьдрал болон иргэдийг ойлгох	Үл тэвчих байдал ба тэвчээр Нэгдлийн алсын хараа Тайван дэлхий	Миний амьдрал ба эх орон Улсын алсын хараа Улс болон өөрийгөө хөгжүүлэх	(Нэгдэл ба үндэстэн угсаатны нэгдлийн ёс зүй) Нэгдэх хэрэгцээ, шаардлага Хойд Солонгосын иргэд ба үндэстэн нэгтгээ хайрлах Нэгдлийн алсын хараа	(Дэлхийн энх тайван ба хүн төрөлхтнийг хайрлах) Бусад соёл, ёс заншлыг ойлгож, хүндэтгэх Дэлхийн энх тайван ба хүн төрөлхтнийг хайрлахыг үйл хэрэг болгохуй	Улс, үндэстний ёс зүй Улс ба ёс зүй Үндэс угсаа ба ёс зүй
Байгаль, хүрээлэн буй орчинтой харьцах харьцаа	Хүний амьдралын үнэ цэнэ	Байгаль орчин ба байгаль орчныг хадгалж, хамгаалах	Жинхэнэ гоо үзэсгэлэн	Хайр ба нигүүсэл	(Байгаль орчин ба ёс суртахуун) Байгаль орчин ба хүний амьдрал Байгаль орчинд ээлтэй амьдрах	(Соёл ба ёс суртахуун) Жинхэнэ гоо үзэсгэлэн Урлаг ба ёс суртахуун Шинжлэх ухаан ба ёс суртахуун	(Амьдрал ба шашин) Амьдралын хязгаар Шашин ба ёс суртахуун	(Төгс амьдрал) Энх тайван амьдралыг эрэлхийлэх Төгс хүн ба төгс нийгэм

**ЭНЭТХЭГ:** нь ёс суртахуун, ёс зүй зэрэг дотоод сэтгэлийн боловсролын асар их уламжлал, соёлтой орон юм. Эртний Энэтхэгийн дотоод сэтгэлийн боловсрол нь буддын шашин, соёлтой салшгүй холбоотой бөгөөд боловсрол мэдлэгийн үндэс нь “мэдлэг” гэх утгатай Вед шастирт оршдог байжээ. Аливаа хүн эрдэм, боловсролд суралцахын өмнө Брахмачарья буюу “биеэ авч явах ёс, хүний ёсны эрдэмд суралцахын тулд эхлээд 4 ведийг судалдаг байсан байна.

Эдгээр 4 вед нь эртний Энэтхэгийн боловсролын тогтолцооны үндэс байсан ба хүний ёс суртахуун, амьдралын утга учир, зөв амьдрах ёс, сайн муу, зөв буруу зэргийг ухааруулж сургадаг сургаал юм. Эрт цагийн багш нарын эрхэм зорилго нь ч шавь нартаа Вед шастир болон туульсын зохиолуудаар дамжуулан ёс зүй ба ёс суртахууны үнэлэмжийг бүтээж, өвлүүлэн уламжлуулдаг байжээ. Ийнхүү уламжлалт ёсоор бол ёс суртахуун, ёс зүй, дотоод сэтгэлийн боловсролыг хүүхэд гэр бүл, соёлын ахуйгаасаа суралцаж олдог байсан нь орчин үеийн завгүй, хурдтай амьдралын дунд замхарч, уламжлал алдагдсан учраас ёс суртахууны үнэ цэнэ, үнэлэмжийн тухай асуудалд ихээхэн анхаарал хандуулж байна. Тухайлбал:

Энэтхэгийн Шарда Их Сургуулийн дэд профессор, доктор Урмила Ядавын “Ёс зүй, ёс суртахууны үнэлэмж ба Энэтхэгийн боловсролын тогтолцоо” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд<sup>64</sup> орчин үеийн Энэтхэгийн боловсролын тогтолцоо ба ёс суртахууны хүмүүжлийн нөхцөл байдлыг дүгнэхдээ: “Модернизаци, аж үйлдвэржилт, хотжилт, хувьчлал, даяаршил ба өрнөдийн соёлын нөлөөлөл зэрэг олон хувьсал өөрчлөлтөөс шалтгаалан Энэтхэгийн боловсролын систем дэх “ёс зүйн үнэлэмж”-ийг доройтуулсан олон зүйл асуудлууд гарах болжээ. Энэтхэгийн боловсролын систем бичиг үсэгт тайлагдсан хүмүүсийн хувь хэмжээг өсгөж байгаа нь сайшаалтай боловч улс нийгэмдээ жинхэнэ эрдэм боловсролтой хүмүүсийг төрүүлэх, улмаар төгс сайн иргэдийг боловсруулахад төдий л хангалтгүй байна. Энэ нь боловсролын эрхэм зорилго нь эх оронч сэтгэл, ёс зүйн үнэлэмжийг хайхралгүйгээр зөвхөн хэрхэн боловсролын зэрэг авах, мөнгө олох, ажил албандаа амжилт гаргахад л анхаарч байгаад оршиж байгаа юм” гэжээ.

Орчин үеийн Энэтхэгийн Боловсролын тухай хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн орчны хүрээнд судлан үзэхэд ёс зүй, дотоод сэтгэлийн боловсролыг олгох тухай тусгайлан зохицуулсан хууль, дүрэм, журам байхгүй хэдий ч боловсролын хөтөлбөрт тусгасан байдаг байна. Энэхүү боловсролын хөтөлбөр нь тав таван жилийн төлөвлөгөөнд хуваагдах ба Засгийн газраас ирэх таван жилийн зорилго, зорилт, сурлагын үр дүн, боловсрол сургалтын үйл ажиллагааны хөтөлбөр, зохион байгуулалтыг тодорхойлдог.

Тус улсын Засгийн газрын “12 дугаар төлөвлөгөө (2012-2017)-ний хөтөлбөр”-т<sup>65</sup> боловсролын хэд хэдэн асуудлыг шийдвэрлэхийг зорьсон байна. Жишээлэхэд: бичиг үсэггүй байдлыг бууруулах, сургууль завсардах

<sup>64</sup>Ethical Moral values and Indian Education System, XVII Annual International Seminar Proceedings; January, 2016 [http://www.internationalseminar.org/XVII\\_AIS/TS5A\\_PDF/7.Urnila%20Yadav.pdf](http://www.internationalseminar.org/XVII_AIS/TS5A_PDF/7.Urnila%20Yadav.pdf)

<sup>65</sup>Twelfth Five Year Plan (2012-2017) [http://planningcommission.gov.in/plans/planrel/12thplan/pdf/12fyp\\_vol3.pdf](http://planningcommission.gov.in/plans/planrel/12thplan/pdf/12fyp_vol3.pdf)



хувь хэмжээг бууруулах, зарим муж улс дахь хичээлд хамрагдалтын байдлыг хянах системийг бий болгох, үнэт зүйлс (бүх нийтийн соёлын, оюун санааны, ёс суртахууны, эрүүл амьдрах хэв маяг, хүрээлэн буй орчны соёл зэргийг оролцуулаад) ба хувийн зан чанарын (бие даасан, эх оронч, энхтайванч, үндэстний эв нэгдэл, шударга, ертөнцийг үзэх үзлийг бүрэлдүүлэх, орчин үеийн шинжлэх ухаан ба нийгмийн амьдрал-практикийн хөгжлийн түвшинтэй хөл нийлүүлэх, өөрөө өөрийгөө хөгжүүлэх ба боловсруулах, бие даасан, хүсэл эрмэлзэл ба чадвартай байх, бүтээлч бөгөөд хариуцлагатай байх) системийг бий болгох, сургуулийн тоог ялангуяа орон нутагт нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутгийн багш нарыг орон сууцжуулах, багш нарын өрсөлдөх чадварыг сайжруулах, багш бэлтгэх сургалтын чанарыг өсгөх гэх мэт асуудлуудыг дурдаж болно.<sup>66</sup>

Дээрх хөтөлбөрт тусгагдсанаар орчин үеийн Энэтхэгийн боловсролын системийн нэн тэргүүний зорилтуудын нэг нь суралцагсдын ёс суртахууны боловсрол байх бөгөөд үүний үндэс нь үндэстний оюун санааг хадгалах, үндэстний нэр хүндийн тухай боловсрол, оюун санаа ба ёс суртахуунлаг байдлыг суралцагчдад төлөвшүүлэн бүрэлдүүлэх байдаг бол Энэтхэгийн ёс суртахууны боловсролын зорилго нь соёл, оюун санаа, ёс суртахуун ба бүх нийтийн үнэт зүйлсийг өвлөн уламжилсан, өөрөө өөрийгөө ямагт боловсруулдаг, ёс суртахууны хувьд ямагт өсөж дэвшиж байдаг хувь хүн болохын төлөө бие, сэтгэл ба оюун санаагаа нэгтгэн хөгжүүлэх үндсэн дээр хүнийг бүх сайн сайхан талаар нь хөгжүүлэхэд оршдог байна.

12 дугаар төлөвлөгөөний хөтөлбөрийн хүрээнд сургуулийн бага ангиудад ёс суртахууны боловсролын үндсийг заахдаа Энхтайвны боловсролын хөтөлбөр (Peace program)-ийг боловсруулан өргөнөөр хэрэгжүүлж эхэлжээ. Энэ нь хүүхдэд амар амгалан, эв нэгдэлтэй байх зан чанарыг төлөвшүүлэх зорилготой хичээл бөгөөд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бусадтай эвсэг, найрсаг байх ухамсрыг суулгахад чиглэсэн хөтөлбөр юм.

Мөн Энхтайвны хөтөлбөрийн зэрэгцээгээр бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, сурагчдын төрөл бүрийн клуб ажиллуулдаг байна. Эдгээр клубууд нь Энэтхэг үндэстний үнэт зүйлс, соёлыг өвлөн хадгалах, эх оронч үзлийн боловсрол олгох, эх орноо хайрлах, түүний дэлхийд эзлэх байр суурь, үүрэг роль, ач холбогдлыг ойлгуулах зэрэгт асар их анхаардаг. Ёс суртахуун, ёс зүй, дотоод сэтгэлийн боловсрол олгох эдгээр арга хэлбэрүүдийн гол зорилго нь хувь хүнийг цогцоор нь төлөвшүүлэн хөгжүүлэх явдал юм. Энэхүү зорилгыг биелүүлэх үүднээс дэвшүүлж буй гол зорилтууд нь:

- Хувь хүний оюун ухаан, соёл ба ёс суртахууны хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэх;
- Сурагчдыг орчин үеийн соёл иргэншлийн орчинд ажиллаж амьдрах чадвартай болгон хөгжүүлэх тухайд иргэний боловсролыг олгох;
- Сайн иргэний боловсролын талаарх үе үеийн туршлагыг ашиглах;

<sup>66</sup>Twelfth Five Year Plan (2012-2017) [http://planningcommission.gov.in/plans/planrel/12thplan/pdf/12fyp\\_vol3.pdf](http://planningcommission.gov.in/plans/planrel/12thplan/pdf/12fyp_vol3.pdf)

- Оюун санааны болон соёлын уламжлалын түүчээг баталгаажуулах;
- Нийгмийн ёс суртахуун, соёл, шинжлэх ухааны үнэ цэнийг өвлөж хөгжүүлэх;
- Хүн ардын дунд мэдлэгийг түгээн боловсрол, соёлын түвшнийг нь өсгөх.

Эдгээр зорилго, зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд боловсрол, танин мэдэхүй, хүмүүсийн ёс суртахууны төлөвшилийг дээшлүүлэх үйл ажиллагаанд багш нар өргөн цар хүрээтэй арга (ярилцлага, тоглоом наадам, урлагийн тоглолт, нийгмийн ажил, биеийн тамир ба бүтээлч ажил үйлс) хэлбэрүүд (хичээл, музей аж ахуйн нэгжүүд, үйлдвэрийн газрууд, клубүүдээр аялал экскурс зохион байгуулах) болон хэрэгслийг (ном сурах бичиг, туульс, үзүүлэн, компьютер, интернэт) ашигладаг байна.

Сүүлийн жилүүдэд Энэтхэгийн ёс суртахууны боловсролын системийн хөгжлийн үйл явцад дараах шинж чанарууд ажиглагдаж байна гэж Оросын судлаач дүгнэжээ<sup>67</sup>. Үүнд: дотоод сэтгэл, бие хүний хөгжил, өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзэл, оюун санааны болон ёс суртахууны тогтмол өсөлт хөгжил, соёл, ёс суртахууны үнэт зүйлс болон уламжлалаас суралцах, иргэнийг төлөвшүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг бүрэлдүүлэх, экологийн сэтгэлгээний үндсийг бүрдүүлэх зэрэг болно.

Гэвч аливаа бусад боловсролын үйл ажиллагааны адилаар ёс суртахууны боловсролыг ямагт шинэчлэн сайжруулж, шинэ хөгжлийн хөтөлбөртэй боловсруулж, түүндээ улс орныхоо өнө эртний түүхэн уламжлалаар шалгагдсан баялаг онол, практик, өрсөлдөх чадвар зэргийг багтаан оруулж байх ёстой гэдэг асуудал тавигдсаар л байгаа аж.

**БУТАН:** Дэлхийд Аз жаргалын яамтай ганцхан улс байдаг нь Бутан юм. Бутан Улс хөгжлийн шалгуур үзүүлэлтийг ДНБ-ээр хэмждэггүй бөгөөд харин түүний оронд өөрсдийн боловсруулсан “нийт үндэстний аз жаргал” гэсэн үзүүлэлтийг шалгуур болгодог байна. Бутан Улс хүн амын тооллого явуулахдаа иргэн бүрээсээ “Та аз жаргалтай байна уу” гэсэн асуултыг асуудаг уламжлалтай. 2015 оны сүүлчээр уг санал асуулгыг явуулахад хүн амын 35 хувь нь “маш их аз жаргалтай”, 47.9 хувь нь “аз жаргалтай” харин 8.8 хувь нь “тийм ч аз жаргалтай биш” гэж хариулжээ.<sup>68</sup>

Нийт үндэсний аз жаргал гэдэг ойлголт нь Бутаны дөрөвдүгээр эзэн хаан Жигмэд Сингэй Ванчүгийн боловсруулан дэвшүүлсэн нийгмийн байгууллын тухай үзэл юм. Ерөнхийдөө энэ өвөрмөц гүн ухаан нь хэрэглээний суурьтай дотоодын нийт бүтээгдэхүүнтэй адилгүй бөгөөд үндэсний аз жаргал нь хүн төрөлхтний материаллаг хэрэгцээ болон оюун санааны сайн сайхны хоорондох тэнцвэрийг хангагч бөгөөд үүнийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн амжилтын чухал нэгэн хэмжүүр индекс гэж үздэг байна.

<sup>67</sup>Moral education in Russia and India: A Comparative Analysis, Medwell journals, 2016 <http://docsdrive.com/pdfs/medwelljournals/sscience/2016/3765-3769.pdf>

<sup>68</sup>Gross National Happiness in Bhutan: A Living Example of an Alternative Approach to Progress <https://repository.upenn.edu/cgi/viewcontent.cgi?article=1003&context=sire>

Иймээс Засгийн газар нь ард түмнээ аз жаргалтай байлгахыг гол зорилгоо болгосон байдаг. Бутан Улсын Засгийн газраас Үндэсний аз жаргалын хөтөлбөрийг<sup>69</sup> боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хөтөлбөрт дурдсанаар: XXI зуун бол хэт их технологийн дэвшил, даяаршил ба нөхөгдөх болоод нөхөгдөшгүй баялгийн тогтворгүй хэрэглээний эрин үе юм. Энэ бүх нийгэм-эдийн засаг, хүрээлэн буй орчин, улс төрийн асуудлуудын дунд хүмүүс боловсролыг амьдралын утга учрыг ухаарах, асуудлуудыг шийдвэрлэх арга замыг олох хэрэгсэл төдийгүй хувь хүний болон ард нийтийн эрэлт хэрэгцээний хоорондох гүүр болж, улмаар бүх нийтээрээ хөгжин дэвжих суурь болно гэж үзэх болжээ. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийн боловсрол нийтийн сайн сайхан, хүн төрөлхтний хөгжил цэцэглэлтээс илүүтэй хувь хүний ололт амжилтыг хэрхэн олох тухай зах зээлийн хүчин зүйлсийг голчлон эрхэмлэж ирсэн билээ. Өнөөдрийн хүүхдүүд бол ирээдүйн иргэд тул өнөө бидний хүүхдэд олгож буй боловсролоос манай дэлхий ямар байх нь шалтгаална. Тиймээс эх дэлхийгээ хадгалан хамгаалахын тулд бид нэгэн дэлхийн үндэстэн болж нэгдэх хэрэгтэй юм. Ингэж гэмээ нь бид сая дэлхий нийтийн асуудлуудын шийдлийг олно. Энэ бүхэнд хүүхдийг ганц өөрийгөө боддог биш харин бусдын хүсэл, нийтийн асуудлыг шийдвэрлэхэд хамтрах чадвартай, баяр баясгалантай хүн болж өсгөхөд илүү анхаарсан, одоогийнхоос огт өөр боловсрол шаардлагатай байна. Энэ нь дан ганц боловсролын байгууллага, багш нарын анхаарах асуудал бус үүнд эцэг, эх болон олон талын оролцоо, хүсэл тэмүүлэл, үйл хэрэг чухал үүрэгтэй болохыг тодорхойлжээ.

Бутаны нийт хүн амын 80.97% нь бурханы шашинтнууд, 17.83% нь хиндү, 1.20% христийн шашинтнууд юм. Үүсгэн байгуулагдсан цагаасаа л Бутаны өвөрмөц соёл нь Бурхны шашин соёлын нөлөө бүхий хөгжиж ирсэн. Тийм учраас Бутаны соёл нь бурхны ном сургаалын зарчмуудад гүн бат суурилсан байдаг байна.<sup>70</sup>

Үндэсний аз жаргалын индекс нь хүн амын материаллаг эд баялаг болон оюун санааны, эрүүл мэндийн тэнцвэртэй байдлыг хадгалж байдаг.

Хөтөлбөрийн хүрээнд 2009 оноос Бутаны Засгийн газар улсын сургуулийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, ирээдүйн Бутаны иргэдийг амьдралын утга учрыг ухааруулах, аз жаргалтай амьдралын талаар ойлголттой болгох, байгаль орчноо хамгаалах дадал хэвшлийг бий болгох, энэ дэлхийн бүх зүйл хоорондоо харилцан хамааралтай болохыг ойлгуулах зорилт тавьжээ.

Энэ ч үүднээс Бутан Улсын Боловсролын яамнаас “Бутаны боловсролын төлөвлөгөө”<sup>71</sup> хэмээх 2014-2024 онд хэрэгжүүлэх боловсролын хөтөлбөр, бодлогын баримт бичгийг 2014 онд боловсруулан хэвлүүлжээ. Энэхүү бодлогын баримт бичгийг “аливаа улс орон агуу хүчирхэг байхын үндэс бол ард түмний бүтээлч байдал, зан суртахуун мөн бөгөөд энэ нь тэдний хүртэж буй боловсролын чанараас хамаарна” гэдэгт итгэдэг Дүжал Шива эзэн хааны лагшин мэндэлсний 60 насны ойд зориулсан байна.

<sup>69</sup>[https://issuu.com/trykpartner/docs/quality\\_of\\_school\\_education\\_in\\_bhut](https://issuu.com/trykpartner/docs/quality_of_school_education_in_bhut)

<sup>70</sup><https://happinesssummit.world/gross-national-happiness-and-positive-education-in-bhutan/>

<sup>71</sup><https://www.globalpartnership.org/content/bhutan-education-blueprint-2014-2024>

Тэрээр хэлэхдээ: “Улс, эх орноо удирдан жолоодоход чухал олон нэн зорилго, зорилтууд бий. Энэ бүхний нэн тэргүүнд миний бие боловсролыг эрхэмлэнэ. Боловсрол бол - нийгмийг тэгшитгэн тэнцвэржүүлэгч, өөрийгөө нээж таних нөхцөлийг бүрдүүлэгч - өөрөө өөрийнхөө бүх чадвар, боломжийг танин мэдэх хүчийг өгөгч мөн. Сайн боловсрол бидэнд өөртөө итгэх итгэлийг, зөв үнэлэлт дүгнэлтийг, сайн буяны сэтгэлийг, улмаар амгалан жаргаланг баттай олохын арга ухааны хайрлах юм. Сайн сургууль хүүхдэд арьс өнгө, удам угсаа, нийгмийн гарлаас нь үл хамааран амжилтанд хүрэх шударга боломж, амьдралын ахиц дэвшлийн баталгааг олгох болно”<sup>72</sup> гэжээ.

Бутаны боловсролын систем нь нэг жилийн бэлтгэл бүхий долоон жилийн суурь боловсрол (бэлтгэлээс VI анги), дөрвөн жилийн дунд боловсрол (VII-X анги), хоёр жилийн ахлах буюу бүрэн дунд боловсрол (XI-XII анги)-оос бүрдэнэ. Бутанд 6 настай элсэн ордог бэлтгэл ангиас X анги хүртэлх ерөнхий боловсрол үнэ төлбөргүй. Гэсэн хэдий ч бүрэн дунд сургууль төгссөний дараа дээд сургуульд суралцагсдыг авьяас чадвар, сурлага, улсын хүний нөөцийн эрэлт зэрэгт нийцүүлэн сонгож Засгийн газрын тэтгэлэгт хамруулна. 12 дугаар ангиа дүүргэсэн боловч Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаж чадаагүй сурагчид хувиараа төлбөрөө төлж дээд боловсролыг эзэмшинэ.


Төлөвлөгөө нь нийт 5 бүлэгтэй бөгөөд 2014-2024 он хүртэл боловсролын талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга зам, хөтөлбөрийн үндэслэл, зорилго, зорилтууд, Бутаны боловсролын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга замууд болон боловсролын системд нэвтрүүлэх өөрчлөлтүүд зэргийг маш тодорхой боловсруулсан байна. Энэхүү төлөвлөгөөнд оруулсан боловсролын системийн бага, дунд, ахлах ангиудын сургалтын хөтөлбөрийг харахад уламжлалт соёл, ёс суртахууны боловсролын хичээлүүдийг бүр бэлтгэл, бага ангиас нь төгсөх анги хүртэл нь шалгалт авахгүй боловч заавал судлах хичээл болгон оруулдаг байна.<sup>73</sup>

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>72</sup>Бутаны Эзэн хаан Жигмэд Хэсар Намжилванчүг. 2014 он.

<sup>73</sup><https://www.globalpartnership.org/content/bhutan-education-blueprint-2014-2024>

Зураг 1. Бутаны боловсролын тогтолцоо



**СИНГАПУР:** Сингапур Улс нь 1965 онд бүх нийтээр бага боловсрол, 1970-аад онд бүх нийтээр бүрэн бус дунд боловсролтой болсон байна.

Сингапур Улсын хувьд ёс зүй, ёс суртахуунтай холбоотой асуудлыг *Character and Citizenship Education (CCE)* буюу Зан суртахуун ба иргэний боловсролын хичээлээр судалдаг байна. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн Зан суртахуун ба иргэний боловсролын хичээлийн зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна.

Зорилтын 1-4 нь хувь хүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн байна. Үүнд:

1. Хувь хүний сайн сайхан үр дүнд хүрэхийн тулд өөрийгөө ойлгуулах, өөрийгөө удирдах чадварыг эзэмшүүлэх;
2. Ёс суртахууны зарчмуудыг дээдэлсэн, шударга зарчмыг баримтлан хариуцлагатай шийдвэр гаргах;
3. Хүмүүсийн харилцан хүндэтгэл дээр суурилсан эерэг харилцааг бий болгоход нийгмийн ухамсар, харилцааны чадварыг ашиглах;
4. Уян хатан байж, сорилт бэрхшээлүүдийг боломж болгох чадвартай байх.

Зорилтын 5-8 нь 21-р зууны иргэнийг удирдлага болгон нийгмийн гишүүний хувьд соёлтой, идэвхтэй, хариуцлагатай оролцоо зэрэг иргэний харьяаллын шинж чанаруудыг төлөвшүүлэхэд чиглэгдэж байна. Үүнд:

5. Улс орондоо харьяалагдах, улс үндэстнээ байгуулахад оролцох, үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанарын (*national identity*) бахархал;
6. Сингапурын нийгэм-соёлын олон янз байдлыг ойлгон үнэлж, нийгмийн нэгдмэл байдал, эв нэгдлийг хөхиүлэн дэмжих, хамгаалах;
7. Бусдын төлөө санаа тавьж, нийгэм, улс үндэстнийхээ хөгжил дэвшилд идэвхтэй хувь нэмэр оруулах;
8. Олон нийт, үндэсний болон дэлхийн асуудлуудад хариуцлагатай, мэдээлэлтэй иргэний хувьд хариулах чадвартай байх.



Хүснэгт 7. Зан суртахуун ба ирээний боловсролын хичээлийн агуулга

Д/д	Иргэний боловсролын хичээлийн зорилго	Зорилго (Боловсролын шат тус бүрт)			Гол үнэт зүйл
		Бага	Дунд	Их сургуулиас өмнөх	
1	Хувь хүний сайн сайхан үр дүнд хүрэхийн тулд өөрийгөө ойлгуулах, өөрийгөө удирдах чадварыг эзэмшүүлэх;	Хөдөлмөрөөрөө бахархах	Сурч боловсрох хариуцлагаа ухамсарлах	Төгс төгөлдрийг илэрхийлэхдээ зорилготой байх	Хариуцлага
		Зөв дадал зуршил, урлагийн талаарх мэдлэг	Биеийн тамираар хичээллэх, урлагийн талаарх мэдлэг	Эрүүл амьдралын хэв маягийг эрэлхийлэх, гоо зүйн мэдрэмж	
2	Ёс суртахууны зарчмуудыг дээдэлсэн, шударга зарчмыг баримтлан хариуцлагатай шийдвэр гаргах;	Буруу, зөвийг ялгах чадвартай байх	Ёс суртахуунтай байх	Зөв гэсний төлөө тэмцэх ёс суртахууны зорилготой байх	Хариуцлага, шударга байдал
3	Хүмүүсийн харилцан хүндэтгэл дээр суурилсан эерэг харилцааг бий болгоход нийгмийн ухамсар, харилцааны чадварыг ашиглах;	Бусадтай хамтран ажиллах, хуваалцах, асран халамжлах чадвартай байх	Багаар ажиллаж, бусдад санаа тавих	Нийгмийн хариуцлагатай байж, янз бүрийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллах чадвартай байх	Хүндлэл
4	Уян хатан байж, сорилт бэрхшэлүүдийг боломж болгох чадвартай байх;	Өөрийн хүч чадал, давуу талаа хөгжүүлэх	Өөрийн үр чадвар, чадалдаа итгэж, өөрчлөгдөж чаддаг байх	Саад бэрхшээлийг даван туулах чадвартай байх	Уян хатан байдал
		Юмс үзэгдлийг сонирхох	Бүтээлч сэтгэлгээтэй байх	Шинэлэг, аж ахуйч байх	
5	Улс орондоо харьяалагдах, улс үндэстнээ байгуулахад оролцох, "national identity" (үндэсний ондоошил/үндэстний ижилсэл/амин чанар)-ын бахархал;	Улс орноо таньж мэдэх, хайрлах	Улс орондоо итгэх итгэл ба юу чухал болохыг ойлгох	Сингапурын иргэн байхын бахархал, дэлхий дахин дахь Сингапурын байр суурийг ойлгох	Хариуцлага

6	Сингапурын нийгэм-соёлын олон янз байдлыг ойлгон үнэлж, нийгмийн нэгдмэл байдал, эв нэгдлийг хөхиүлэн дэмжих, хамгаалах;	Бусадтай хамтран ажиллах, хуваалцах, асран халамжлах чадвартай байх	Багаар ажиллаж, бусдад санаа тавих	Нийгмийн хариуцлагатай байж, янз бүрийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллах чадвартай байх	Хариуцлага, эв нэгдэл
		Өөртөө итгэлтэйгээр өөрийгөө илэрхийлэх, сэтгэж бодох	Олон янзын үзэл бодлыг ойлгож, харилцах чадвартай байх	Шүүмжлэлтэйгээр бодож, үнэмшилтэйгээр харилцах чадвартай байх	
7	Бусдын төлөө санаа тавьж, нийгэм, улс үндэстнийхээ хөгжил дэвшилд идэвхтэй хувь нэмэр оруулах;	Өөрийн хүч чадал, давуу талаа хөгжүүлэх	Өөрийн үр чадвар, чадалдаа итгэж, өөрчлөлтөд дасан зохицох чадвартай байх	Саад бэрхшээлийг даван туулах чадвартай байх	Хариуцлага, халамж
		Бусадтай хамтран ажиллах, хуваалцах, асран халамжлах чадвартай байх	Багаар ажиллаж, бусдад санаа тавих	Нийгмийн хариуцлагатай байж, янз бүрийн улс үндэстэн, соёлтой хамтран ажиллах чадвартай байх	
		Юмс үзэгдлийг сонирхох	Бүтээлч сэтгэлгээтэй байх	Шинэлэг, ажл ахуйч байх	
8	Олон нийт, үндэсний болон дэлхийн асуудлуудад хариуцлагатай хандаж, мэдээлэлтэй иргэний хувьд хариулах чадвартай байх.	Буруу, зөвийг ялгах чадвартай байх	Ёс суртахуунтай байх	Зөв гэсний төлөө тэмцэх ёс суртахууны зоригтой байх	Хүндлэл, хариуцлага
		Өөртөө итгэлтэйгээр өөрийгөө илэрхийлэх, сэтгэж бодох	Олон янзын үзэл бодлыг ойлгож, харилцах чадвартай байх	Шүүмжлэлтэйгээр бодож, үнэмшилтэйгээр харилцах чадвартай байх	
		Улс орноо таньж мэдэх, хайрлах	Улс орондоо итгэх итгэл ба юу чухал болохыг ойлгох	Сингапурын иргэн байхын бахархал, дэлхий дахин дахь Сингапурын байр суурийг ойлгох	

## **ХОЁР. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ЁС СУРТАХУУНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХООР ХУУЛЬ, ХОЛБОГДОХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАСАН УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА**

### **2.1. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС**

21-р зууны эхээр Оросод улс төр, нийгэм, эдийн засгийн чухал өөрчлөлтүүд явагдсан нь нийгмийн ухамсрын түвшинд ихээхэн нөлөө үзүүлсэн. Өөрөөр хэлбэл, одоо Оросын нийгэм ёс суртахуун болон хүмүүжлийн хямралд ороод байна. Энэ нь өсвөр үеийн хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролд ноцтой нөлөө үзүүлж байна. Иймээс сүүлийн 10 жилд төр засгаас гэр бүлийн нийгэм, эдийн засгийн асуудал, мөн хүүхэд, залуусын ёс суртахуун, хүмүүжил төлөвшлийн асуудлыг бүх талаар дэмжиж, хууль эрх зүйн хүрээнд зохицуулах талаар ихээхэн анхаарал хандуулсан. Тухайлбал, 2012 онд Ерөнхийлөгчийн зарлигаар “Хүүхдийн төлөө Үндэсний Стратеги 2012-2017” хүчин төгөлдөр болсон.

Засгийн газраас 2015 онд “*2025 он хүртэл ОХУ-ын хүмүүжлийн боловсролын хөгжилд баримтлах стратеги*”-ийг (Стратегия развития воспитания в Российской Федерации на период до 2025 года) батлан гаргасан<sup>74</sup>.

ОХУ нь хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны асуудлыг зохицуулах тусдаа хуульгүй. Харин хүүхэд, гэр бүлийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулах хууль, дүрэм, журам болон хөтөлбөрийн хүрээнд зохицуулдаг.

Энэхүү асуудлыг зохицуулахад “*2025 он хүртэл ОХУ-ын хүмүүжлийн боловсролын хөгжилд баримтлах стратеги*” чухал үүрэг гүйцэтгэж байна. Стратеги нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, 1998 оны “Оросын Холбооны Улсын хүүхдийн үндсэн эрхийн баталгааг хангах тухай” хууль (“Об основных гарантиях прав ребёнка в Российской Федерации”), 2012 оны “Оросын Холбооны Улсын боловсролын тухай хууль” (“Об образовании в Российской Федерации”) болон бусад холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах зорилготой. Уг стратегид тодорхойлсноор ОХУ-ын тэргүүний зорилтуудын нэг нь 21-р зууны шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадвартай, уламжлалт ёс суртахууны үнэ цэнийг хадгалсан, эх орны бүтээн байгуулалт болон эх орноо хамгаалах үйлсэд хэзээд бэлэн шинэ үеийг төлөвшүүлэх явдал юм. Энэ асуудлыг шийдэх гол түлхүүр нь хүүхдийн хүмүүжил юм. Хүмүүжлийн стратегийн чиг хандлагыг Ерөнхийлөгч Путин: “Эх орон болон эх дэлхийгээ хайрладаг, бүх үндэстэн болон угсаатанд адил тэгш ханддаг, хөрш зэргэлдээ амьдарч буй хүмүүсийн түүх соёл, ёс заншилд хүндэтгэлтэй ханддаг бүх талаар боловсорсон, хариуцлагатай иргэн хүнийг төлөвшүүлэх юм” хэмээн тодорхойлон хэлжээ.

<sup>74</sup>[https://минобрнауки.рф/открытое\\_министерство/стратегия/](https://минобрнауки.рф/открытое_министерство/стратегия/)  
Стратегия развития воспитания в Российской Федерации на период до 2025 года  
Распоряжением Правительства РФ от 29.05.2015 г. № 996-р

**Стратегийн зорилго** нь хүүхдийн хүмүүжлийн талаарх төрийн нэн тэргүүний бодлого, хүмүүжлийн боловсролыг хөгжүүлэх үндсэн чиг хандлага, уг стратегийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг тодорхойлох, түүнчлэн орос иргэнийг илэрхийлэх хувь хүнийг төлөвшүүлэх, нийгэм дэх ёс суртахууны үндэс суурийг бэхжүүлэх, хүүхдийг үр дүнтэй нийгэмшүүлэх, Оросын Холбооны Улс дахь олон үндэстний үнэт зүйл болон ёс заншил, соёлыг судалж таних, хүндэтгэлтэй хандахад оршино.

**Стратеги нь дараах зорилтуудыг агуулна. Үүнд:**

- өсвөр үеийг хүмүүжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд хамтарч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ба хүүхдийн хүмүүжилд гэр бүл чухал үүрэгтэй болохыг онцгойлон анхаарах;
- хүүхэд хүмүүжүүлэхэд эцэг эхийн хариуцлагад тулгуурласан гэр бүлийн хүмүүжлийг дэмжих, түүнчлэн эцэг эхийн нийгмийн, харилцааны, сурган хүмүүжүүлэх мэдлэгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- боловсролын системийн хүмүүжилтэй холбоотой үйл ажиллагааны ач холбогдлыг нэмэгдүүлэх;
- хүүхдийг үр дүнтэй нийгэмшүүлэхэд боловсрол, соёл, биеийн тамир, шинжлэх ухаан, танин мэдэхүй, аялал жуулчлал болон бусад байгууллагын хамтын ажиллагааг хангах, нийгэм соёлын дэд бүтцийг бүрдүүлэх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирсон дэд бүтцийг бүрдүүлэх, тэгш хүртээмжтэй хангах юм.

**Стратеги нь 4 хэсгээс бүрддэг. Үүнд:**

- Хүмүүжлийн боловсролд баримтлах төрийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд;
- Хүмүүжлийн боловсролыг хөгжүүлэх үндсэн чиг хандлагууд;
- Стратегийг хэрэгжүүлэх арга механизм;
- Хүлээгдэж буй үр дүн зэрэг болно.

### **Хүмүүжлийн боловсролд баримтлах төрийн бодлогын тэргүүлэх чиглэлүүд**

- хүүхдийг эрхэм чанар, үндэсний ёс заншил болон хүн төрөлхтний ололт амжилтад хүндэтгэлтэй хандахад төлөвшүүлэх, мөн хүүхдийн хүмүүжилд гэр бүлийн үүрэг оролцоог онцгойлон дэмжих, эцэг эхийн нэр хүндийг эрхэмлэх, тэдний хүүхдээ сурган хүмүүжүүлэх нэн тэргүүний эрх ашгийг хамгаалах;
- хүүхэд бүрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
- боловсролын систем дэх хүмүүжлийн асуудлыг үндэсний уламжлалт соёл, ёс суртахуун, хүмүүжил төлөвшил, гэр бүлийн үнэт зүйлстэй уялдуулан зохицуулах;
- хүүхдийн бие, сэтгэл зүй, нийгмийн байдал, ёс суртахуун, хүмүүжил, төлөвшилийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх, ялангуяа хүнд нөхцөлд буй хүүхдэд онцгой анхаарал хандуулах (үүнд: эцэг эхийн асран хамгаалалд байдаггүй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үндэстэн хоорондын болон зэвсэгт мөргөлдөөний уршгаар, эсхүл экологийн болон техногений осол гамшиг, эсхүл байгалийн давагдашгүй хүчин зүйлийн золиос болсон

хүүхэд, дүрвэгсдийн гэр бүлд буй, эсхүл нүүлгэн шилжүүлсэн нөхцөлд буй хүүхэд, ял авч эрх нь хязгаарлагдсан буюу засан хүмүүжүүлэхэд буй хүүхэд, бусад тохиолдол), мөн орчин тойронтой харьцах хандлагыг төлөвшүүлэх;

- хүүхдийн хэл ярианы соёлыг төлөвшүүлэх;

Оросын ирээдүйн иргэн өсвөр үеийг төлөвшүүлэх, хүмүүжлийн орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор хүмүүжлийн боловсролд хамааралтай субъектүүдийн, өөрөөр хэлбэл гэр бүл, нийгэм, улс төр, боловсрол, шинжлэх ухаан, уламжлалт шашны болон төрийн бус байгууллагууд, биеийн тамир болон соёлын байгууллагууд, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого баримтлах зэрэг болно.

## **ХҮМҮҮЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГ ХАНДЛАГУУД**

Үндсэн чиг хандлагыг 2 бүлэгт хувааж үзсэн. Үүнд;

- 1.Хүмүүжлийн чиг үүрэг бүхий нийгмийн институцийг хөгжүүлэх;
- 2.Уламжлалт ёс заншилд үндэслэж, орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэй уялдуулан хүмүүжлийн үйл ажиллагааг шинэчлэх.

### **1. Хүмүүжлийн чиг үүрэг бүхий нийгмийн институцийг хөгжүүлэх**

Энэ хүрээнд дараах 4 зүйлийг тодорхойлсон. Үүнд:

- Гэр бүлийн хүмүүжлийг дэмжих;
- Боловсролын систем дэх хүмүүжлийн асуудлыг сайжруулах;
- Мэдээллийн хэрэгсэл ашиглаж хүмүүжил олгох боломжийг нэмэгдүүлэх;
- Хүмүүжлийн чиг үүрэг бүхий олон нийтийн байгууллага, холбоодыг дэмжих зэрэг болно.

#### **Гэр бүлийн хүмүүжлийг дэмжихэд**

- хүүхдийг сурган хүмүүжүүлэхэд гэр бүлийн харилцааг бэхжүүлэх болон эцэг эхийн нэн тэргүүний эрхийг хамгаалах; олон хүүхэдтэй байх, эцэг эх байхын нийгмийн ач холбогдол болон нэр хүндийг дээшлүүлэх;
- хүүхэд хүмүүжүүлэхэд гэр бүлийн харилцааны соёлыг уламжлалт болон ёс суртахууны үнэт зүйл, уламжлалт шашны ёс заншилд тулгуурлаж хөгжүүлэх, хамгаалах, бэхжүүлэх;
- гэр бүлд хүүхэд хүмүүжүүлэх, ялангуяа олон хүүхэдтэй болон хүүхэд үрчлэн өсгөж буй тохиолдолд хамгийн оновчтой сурган хүмүүжүүлэх туршлагыг дэлгэрүүлэх;
- удмын холбоо, төрөл садны холбоог бэхжүүлэх, олон үе дамжин өвлөгдөж ирсэн гэр бүлийн ач холбогдол бүхий уламжлалыг сэргээн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- боловсролын байгууллага болон хүүхэдтэй ажилладаг бусад байгууллагын хүмүүжүүлэх үйл ажиллагаанд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх;

- боловсролын болон нийгмийн байгууллагуудын оролцоотой эцэг эхийн сурган хүмүүжүүлэх соёлыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Амралтын хугацаанд гэр бүлийн амрах болон боловсролын ач холбогдолтой аялал жуулчлалыг дэмжих дэд бүтцийг сайжруулах;
- гэр бүлийн клубүүд, оршин суугаа газар дахь клубүүд, гэр бүл болон эцэг эхийн холбоодыг дэмжих (эдгээр клуб нь гэр бүлийн харилцааг бэхжүүлэх, мөн гэр бүл, ёс суртахууны уламжлалт харилцааг, гэр бүлийн харилцааны соёлыг, гэр бүлийн хүмүүжилд эцгийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх хамгаалах, сэргээх зорилготой);
- гэр бүлийн хүмүүжлийн хүрээнд эрх зүй, эдийн засаг, анагаах ухаан, сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх болон бусад асуудлаар эцэг эхэд мэдлэг боловсрол, зөвлөгөө өгөх нөхцөлийг бүрдүүлэх юм.

#### Боловсролын систем дэх хүмүүжлийн асуудлыг сайжруулахад

- төрийн боловсролын стандартад тусгасан хүмүүжлийн цогц асуудлыг үр дүнтэй хэрэгжүүлэх, түүнд үндэслэж хүмүүжлийн боловсролын агуулгыг шинэчлэх, мөн сурган хүмүүжүүлэх хамгийн оновчтой туршлагад тулгуурлаж хүмүүжлийн арга болон хэлбэрийг нэвтрүүлэх;
- эцэг эх, гэр бүл, ахмад хүнийг хүндэтгэх, мөн ирээдүйд гэр бүл болох талаар хүмүүжил өгөхөд чиглэсэн боловсролын хөтөлбөрийг уламжлалт гэр бүлийн харилцаа болон ёс суртахууны хүмүүжил төлөвшилд тулгуурлан боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- суурь болон нэмэлт сургалтын хөтөлбөрүүдэд тусгасан хүмүүжилтэй холбоотой хэсгийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэх;
- хүүхдийн хэрэгцээ, ашиг сонирхол, чадварыг харгалзан түүний хөгжлийн үе шатыг төлөвшүүлэхэд шаардлагатай хүмүүжлийн систем болон технологийг хөгжүүлэх;
- авьяас чадвартай хүүхдийг тодруулах, дэмжих нөхцөлийг сайжруулах;
- хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх танин мэдэхүй, хөдөлмөрт сургах, нийгмийн хэрэгцээтэй, урлагийн, биеийн тамирын болон тоглоомын хэлбэрийг нэмэлт боловсролын системийн нөөц бололцоог ашиглаж хөгжүүлэх;
- өсвөр үеийн ном зохиол унших сонирхлыг хөгжүүлэх;
- хүүхдийн орос хэлний болон эх хэлний ур чадвар, харилцааны бусад чадваруудыг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэх;
- хүүхдийн амралтыг зохион байгуулах, эрүүл мэндийг хамгаалахад хүмүүжлийн холбогдолтой сэтгэл зүйн болон сурган хүмүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх юм.

#### Мэдээллийн хэрэгсэл ашиглаж хүмүүжил олгох боломжийг нэмэгдүүлэхэд

- интернэт, кино, телевиз, ном, сонин хэвлэл, ялангуяа радио, телевиз зэрэг мэдээллийн орчин нь хүүхдийн хөгжилд эерэг нөлөөтэй байх нөхцөлийг бүрдүүлэх;

- Оросын уламжлалт соёл, ёс суртахуун, хүмүүжил, төлөвшил, гэр бүлийн үнэт зүйлсийн талаар мэдээллийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлэхийг дэмжих;
- интернэтийн эх сурвалжид нэвтэрснээр хүүхдийн эрүүл мэнд болон хөгжилд буруугаар нөлөөлөх мэдээллээс хүүхдийг хамгаалах юм.

Хүмүүжлийн чиг үүрэг бүхий олон нийтийн байгууллага, холбоодыг дэмжихэд

- Хүүхдийн манлайлах болон бүтээлч чадварыг хөгжүүлэх зорилгоор хүүхдийн байгууллага, олон нийтийн байгууллагуудын ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, нэмэлт боловсролын байгууллагуудтай үр дүнтэй харилцааг сайжруулах;
- боловсролын байгууллагын хүмүүжүүлэх үйл ажиллагаанд эцэг эхийн болон олон нийтийн байгууллага, холбоодын оролцоог дэмжих;
- нийгмийн ач холбогдолтой танин мэдэхүйн, урлаг соёлын, орон нутгийн, буяны байгууллагуудын үйл ажиллагаанд, мөн сайн дурын үйл ажиллагаанд хүүхдийг өргөнөөр оролцуулах;
- хүүхдийн хүмүүжлийн хүрээнд төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх юм.

**2. Уламжлалт ёс заншилд үндэслэж, орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэй уялдуулан хүмүүжлийн үйл ажиллагааг шинэчлэх**

Үүнд дараах 6 зүйлийг тодорхойлсон.

- Иргэний болон эх оронч хүмүүжил;
- Ёс суртахуун, хүмүүжил төлөвшлийг сайжруулах;
- Соёлын өв уламжлалтай харьцах;
- Биеийн хөгжил ба эрүүл мэндийн соёл;
- Хөдөлмөрт сургах болон мэргэжлээ сонгох;
- Экологитой харьцах харилцаа зэрэг болно.

Иргэний болон эх оронч хүмүүжил

- ертөнцийг үзэх үзэл, Орос орны онцлог, гэр бүл, нийгэм, төрд, мөн гэр бүл болон нийгэмд буй ёс суртахуун, хүмүүжлийн, нийгэм соёлын үнэт зүйлсэд, үндэсний түүх соёлын өв уламжлалд хүндэтгэлтэй хандах, түүнийг хамгаалах, хөгжүүлэхэд хүүхдийг төлөвшүүлэн хүмүүжүүлэх;
- Оросын нийгмийн уламжлалт соёл, ёс суртахуун, хүмүүжлийн үнэт зүйлд тулгуурлаж хүүхдийг идэвх санаачилгатай байх, иргэний үүрэг хариуцлагаа ухамсарлах, мэдлэг боловсрол, чадвараа хөгжүүлэх, Үндсэн хуулиар хүлээсэн эрх, үүргээ хариуцлагатай биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- хүүхдийн эрх зүйн болон улс төрийн харилцааны соёлыг хөгжүүлэх, хүүхдийн эрх, ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргахад тэдний идэвхтэй оролцоог хангах;
- хүүхдэд эх оронч үзлийг, цэргийн хүний адил эх оронч үзлийг төлөвшүүлэх;



- цагаач хүүхдийн хууль эрх зүй, нийгэм соёлын харилцааг хөгжүүлэхэд тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- хэт туйлшрал, ксенофоби буюу гадаадын хүмүүсийг ялгаварлан гадуурхах, мөн нийгмийн гарал, шашин шүтлэг, арьс өнгө, үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах, үндэстэн хоорондын, шашин хоорондын зөрчил болон нийгмийн бусад сөрөг хандлагад автуулахгүй, ёс суртахуунтай байх, зөв зохистой хүмүүжил, үзэл бодол, хандлагыг төлөвшүүлэх юм.

#### Ёс суртахуун, хүмүүжил төлөвшлийг сайжруулахад

- хүүхдийг сайхан сэтгэлтэй, үнэнч шударга, зөв боловсон хүмүүжүүлэх, эцэг эх, багш, ахмад хүмүүс, найз нөхөд болон бусад хүмүүст хүндэтгэлтэй хандах, мөн хариуцлагатай байх, сонголтоо зөв хийх, багаар ажиллах чадвартай, эв найрамдалтай, өрөвч энэрэнгүй, нинжин сэтгэлтэй, хүүхэд болон ахмад настанд ээлтэй, тусч, бэрхшээлийг даван туулах чадварт төлөвшүүлэн хүмүүжүүлэх;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүндэтгэлтэй хандах хандлагыг төлөвшүүлэх;
- хүүхдийн ёс суртахуун, хүмүүжлийн хүрээнд төр, нийгэм, уламжлалт шашны болон олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх юм.

#### Соёлын өв уламжлалтай харьцах

- хүүхэд бүр соёлын үнэт зүйлтэй харьцах боломжийг бүрдүүлэх;
- хүүхэд гэр орондоо хүүхдийн ном зохиол унших, мөн сонгодог, орчин үеийн үндэсний болон дэлхийн уран зохиолтой танилцах нөхцөлийг сайжруулах;
- Оросын уламжлалт соёл, ёс суртахууны болон гэр бүлийн үнэт зүйлсийг сурталчлан таниулах ач холбогдол бүхий соёл урлагийн арга хэмжээг дэмжих;
- хүүхдийн оюун ухаан болон ёс суртахууны хөгжилд эерэг нөлөөтэй уран сайхны, баримтат, шинжлэх ухаан танин мэдэхүйн, сургалтын, хөдөлгөөнт кино хийхийг дэмжих;
- номын сангийн үйл ажиллагааг дэмжих;
- үндэсний соёл урлагийн бүтээл, ёс заншлыг хамгаалах, дэмжих нөхцөл бүрдүүлэх юм.

#### Биеийн хөгжил ба эрүүл мэндийн соёл

- өсвөр үеийг өөрийн эрүүл мэндэд хариуцлагатай анхаарах, эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлэх;
- хүүхэд бүр биеийн тамираар хичээллэх нөхцөл бүрдүүлэх, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, чийрэгжүүлэх, үүнд хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд нөхцөлд буй хүүхдийг мөн адил хамруулах, мөн биеийн тамирын хувьд дэд бүтцийг хөгжүүлэх, түүний үр ашигтай хэрэглээг хэвшүүлэх;

- аюулгүй амьдрах ухаанд сургах, муу зуршлаас сэргийлэх;
- хүүхдийн орчинд идэвхтэй, эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлэх, биеийн тамираар хичээллэх, зөв боловсон хооллох, эрүүл хоол хүнс хэрэглэх, нийтийг хамарсан биеийн тамирын үйл ажиллагааг дэлгэрүүлнэ.

#### Хөдөлмөрт сургах болон мэргэжлээ сонгоход

- хөдөлмөрт, хөдөлмөрлөж буй хүнд, хөдөлмөрлөсний үр дүнд хүрсэн ололт амжилтад хүндэтгэлтэй хандахад сургах;
- өөрт хамааралтай зүйлийг бие даан хийх чадвар эзэмшүүлэх, гэрийн ажилд туслах, хөдөлмөрлөх хэрэгцээг ойлгуулах, ямар ч ажил хөдөлмөрт чин сэтгэлээс хариуцлагатай, бүтээлч хандлагыг төлөвшүүлэх;
- бусадтай хамтарч ажиллахад идэвх санаачилгатай, хариуцлагатай, өөрт буй нөөц боломжоо дайчлан ажиллах, хийсэн үйлдлийн утга учир, үр дагаврыг зөв үнэлэх чадварыг хөгжүүлэх;
- мэргэжлээ зөв сонгоход нөлөөлөх нийгмийн ач холбогдолтой үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог, мөн түүний мэргэжлээ сонгох сонголтыг дэмжих юм.

#### Экологитой харьцах харилцаа

- хүүхдийн экологитой соёлтой харьцах, эх нутгаа хайрлах хандлагыг төлөвшүүлэн хөгжүүлэх;
- экологийн талаарх ойлголтыг төлөвшүүлэх, байгаль орчныг хайрлан хамгаалах хүсэл тэмүүллийг хөгжүүлэх;
- байгалийн нөөц ба түүний зүй зохистой хэрэглээг хариуцлагатай ухамсарлах хандлагыг төлөвшүүлэх юм.

СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА МЕХАНИЗМ-ыг дараах 6 хүрээнд авч үзсэн.

#### Эрх зүйн хүрээнд

- холбооны, бүс нутгийн, хотын хэмжээний хүүхдийн хүмүүжилтэй холбоотой хууль, эрх зүйг хүмүүжлийн хүрээнд баримтлах төрийн бодлоготой уялдуулан боловсронгуй болгох, хэрэгжүүлэх;
- хүүхдийг сурган хүмүүжүүлэхэд гэр бүлийн онцгой үүрэг оролцоо болон эцэг эхийн нэн тэргүүний эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг сайжруулах, тэдний боловсролын системд хамааралтай эрх, ашиг сонирхлыг хамгаалах.

#### Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

- Стратегийг хэрэгжүүлэх 3 жилийн хугацаатай цогц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;

- хотын болон бүсийн түвшинд хүмүүжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын санаа санаачилгыг нэгтгэх;
- боловсролын системийн үйл ажиллагааны уялдаа холбоог үр дүнтэй зохицуулах;
- ерөнхий боловсрол, нэмэлт боловсролын байгууллагууд болон хүмүүжлийн чиг үүрэг бүхий бусад байгууллагуудын харилцаа холбоог дэмжих;
- гэр бүл, боловсролын байгууллага болон хүмүүжлийн чиг үүрэг бүхий бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- хүмүүжлийн хүрээний хамгийн сайн сурган хүмүүжүүлэх туршлагыг системтэй судалж, нэвтрүүлэх;
- боловсролын системд хүмүүжлийн үр нөлөөг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийн тогтолцоог бий болгох;
- ОХУ-ын болон хотын түвшний субъектүүдэд Стратегийн хэрэгжилтийн үр нөлөөг хянах ажлыг зохион байгуулах юм.

### Боловсон хүчний хүрээнд

- багш, сурган хүмүүжүүлэгчийн мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах уур амьсгалыг бүрдүүлэх, үүнд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, дэмжин ажиллах;
- боловсон хүчний чадавх, багш, сурган хүмүүжүүлэгчийн ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжлийн системд мэргэжлийн стандартыг боловсруулж нэвтрүүлэх;
- эцэг эхчүүдийн сурган хүмүүжүүлэх ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- боловсролын системийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг орчин үетэй зохицуулан хөгжүүлэх, орчин үеийн нийгмийн хэрэгцээтэй уялдуулан салбарын боловсон хүчнийг мэргэжил дээшлүүлэх, дахин бэлтгэх юм.

### Шинжлэх ухаан-арга зүйн хүрээнд

- хүүхдийг хүмүүжүүлэх болон нийгэмшүүлэх хүрээнд шинжлэх ухааны судалгаа хийх;
- гэр бүл болон гэр бүлийн хүмүүжлийн талаарх судалгааны ажлыг өргөжүүлэх;
- хүүхдийн хүмүүжил төлөвшилд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэтийн үр нөлөө болон байршлын талаар судалгаа хийх;
- Стратегийг хэрэгжүүлэх арга зүйг боловсруулах.

### Санхүүжилтийн хүрээнд

- хүмүүжлийн боловсролыг хөгжүүлэхэд шаардлагатай нөөц, санхүүжилтээр хангах;

- холбооны, бүс нутгийн болон орон нутгийн төсвөөс хүмүүжлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, түүнчлэн төр хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалт татан оролцуулах, хөрөнгө оруулалтын эх үүсвэр буюу янз бүрийн сувгаар санхүүжүүлэх;
- хүмүүжүүлэх чиг үүрэг бүхий субъектүүдийн хувьд уян хатан системийг бий болгох, түүний үйл ажиллагааг үр бүтээлтэй зохион байгуулах юм.

### Мэдээллийн хүрээнд

- хүмүүжлийн системд хамааралтай субъектүүдийн харилцаа холбоог хангахад орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологи, цахим мэдээллийн эх үүсвэр болон хэрэгслийг ашиглах;
- хүүхдийн эрх ашгийн төлөө боловсролын байгууллагуудын харилцаа холбоог хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хүмүүжилд зайны сургалтын хэлбэрийг ашиглах;
- Стратегийг хэрэгжүүлэхэд холбооны болон бүс нутгийн хэмжээний хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг оролцуулах юм.

### ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Стратегийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэх юм.

- олон нийтэд хүмүүжлийн ач холбогдлыг ойлгуулах;
- хувь хүний төлөвшил, улс дахь үндэстэн бүрийн үнэт зүйл, нийгмийн тогтвортой байдал болон эв нэгдлийг бэхжүүлэх;
- гэр бүлийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, эцэг эх байхын утга учрыг ухамсарлах, гэр бүлийн уламжлалт үнэ цэнийг сэргээх, өвлөн хадгалах, гэр бүлийн уламжлалт хүмүүжлийг бэхжүүлэх;
- төр, нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, орчин үеийн дэд бүтцийн хөгжлийг ашиглах, эрх зүйн зохицуулалт хийх, үр ашигтай удирдлагаар хангах, хүмүүжлийн үйл ажиллагаанд хамгийн сайн сурган хүмүүжүүлэх туршлагыг хэрэгжүүлэх замаар хүмүүжлийн системийг хөгжүүлэх;
- хүүхэд бүрийн хувьд тэдний амьдардаг орчин нөхцөл, амьжиргааны түвшин, эрүүл мэндийн байдлыг үл харгалзан чанартай хүмүүжил олгох, хүүхдийн хэрэгцээ шаардлагыг хангах, бүтээлч чадварыг хөгжүүлэх;
- амьдардаг орчин нөхцөл, нийгмийн байдал, амьжиргааны түвшинг үл харгалзан гоц авьяастай хүүхдийг дэмжих зорилгоор холбооны, бүсийн, хотын түвшний хөтөлбөрүүдийг боловсруулж үр дүнтэй хэрэгжүүлэх;
- хүмүүжлийн системийн боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх, хөгжүүлэх;
- хүүхдийн орчинд эерэг зан төлвийг хэвшүүлж, нийгэм дэх сөрөг үзэгдлийн үр дагаврыг бууруулах;
- хүүхэд залуучуудын хамтын үйл ажиллагааг байнга дэмжих, хүүхэд, эцэг эх, гэр бүлийг хамарсан нийгмийн ач холбогдолтой үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжих;
- хүмүүжлийн холбогдолтой шинжлэх ухааны судалгааны ач холбогдлыг нэмэгдүүлэх;

- мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах;
- Стратегийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх үзүүлэлт болон хяналтын тогтолцоог бий болгох юм.

Оросын хүмүүжлийн стратегийн гол онцлогуудын нэг хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдийн хүмүүжил төлөвшил, мэдлэг боловсрол, хөгжлийн асуудлыг тусгасан явдал юм. Түүнчлэн цагаач хүүхдийн хууль эрх зүй, нийгэм соёлын харилцааг хөгжүүлэхэд тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр заасан байна.

Ер нь хүүхэд хүмүүжүүлэх нь зөвхөн эцэг эх, боловсролын байгууллагын үүрэг биш, төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн холбоод гэх мэт нийгэм дэх бүх байгууллага, хүмүүсийн асуудал учраас тэдний үүрэг оролцоо, хамтын ажиллагааг хангах, дэмжих, хөгжүүлэх талаар энэхүү стратегид тодорхой тусгасан.

Стратегийн сул тал нь ёс суртахуун, хүмүүжил төлөвшлийн боловсролыг хүүхдэд хэдэн наснаас, ямар түвшинд, хэрхэн олгох талаар дурдаагүй байна.

Ер нь улс орны төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтүүд нь нийгмийн ухамсрын түвшинд ихээхэн нөлөө үзүүлдэг. Ийнхүү янз бүрийн нөлөөний улмаас тухайн нийгэм ёс суртахуун, хүмүүжлийн хямралд орж болзошгүй. Энэ нь өсвөр үеийн хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролд ноцтой нөлөө үзүүлдэг. Иймээс гэр бүлийн нийгэм, эдийн засгийн асуудал, мөн хүүхэд, залуусын ёс суртахуун, хүмүүжил төлөвшлийн асуудлыг бүх талаар дэмжиж, цаг үеэ олсон, зүй зохистой, оновчтой шийдвэр гаргаж хэрэгжүүлэх нь чухал юм.

## **2.2.БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС**

Казахстан Улсын хувьд хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны боловсролын тухай тусдаа хууль байхгүй, харин хөтөлбөр хэрэгжүүлдэг. Боловсролын тухай хуулийн 11-р зүйлд боловсролын системийн үүргийг тодорхойлсон бөгөөд энд хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролын талаар дараах заалтуудыг тусгасан байна.<sup>75</sup> Үүнд:

- Үндэсний болон хүн төрөлхтний үнэт зүйлд, мөн шинжлэх ухаан, технологийн ололт амжилтад тулгуурлан хувь хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэхэд чиглэсэн чанартай боловсрол олгох нөхцөлийг бүрдүүлэх;
- хувь хүний бүтээлч чанар, оюуны болон биеийн чадварыг хөгжүүлэх, зөв эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, хувь хүнийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх замаар оюуны чадамжийг хөгжүүлэх;
- иргэний болон эх оронч үзэл, Эх орон – Бүгд Найрамдах Казахстан Улсыг хайрлах, төрийн бэлгэ тэмдэг болон төрийн хэлийг эрхэмлэх, үндэсний ёс заншлыг хүндэтгэх, Үндсэн хуульд харшилсан болон нийгмийн эсрэг аливаа үйлдлийг үл тэвчих чанаруудыг төлөвшүүлэх;
- Идэвх санаачилгатай хувь хүнийг төлөвшүүлэх, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын арга хэмжээнд оролцох, хувь хүний эрх ба үүргийн талаарх ухамсартай үзэл бодлыг төлөвшүүлэх;

<sup>75</sup>[http://adilet.zan.kz/kaz/docs/Z070000319\\_](http://adilet.zan.kz/kaz/docs/Z070000319_)  
Боловсролын тухай хууль, 11-р зүйл

- Үндэсний болон дэлхийн соёлын ололттой танилцах, казах үндэсний болон улс дахь бусад үндэстний түүх, зан заншил, ёс журмын талаар судлах, мөн төрийн хэл, орос болон гадаад хэл сурах нөхцөл боломжуудыг бүрдүүлэх юм.

2010 оноос Сара Назарбаевын санаачилгаар хүүхэд, залуучуудад хүмүүжил, төлөвшил, ардын өв уламжлал, ёс суртахууны боловсрол олгох зорилгоор “Өөрийгөө таних” хөтөлбөрийг боловсролын системд нэвтрүүлэн хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөрийг анх 2001 оноос туршилтын шугамаар зарим боловсролын байгууллагад хэрэгжүүлсэн. Эхний ээлжинд цэцэрлэг, сургууль, коллеж, их дээд сургуулийг хамарсан нийт 184 байгууллагад 9 жил туршилтын шугамаар явуулж, сайн боловсруулсны үр дүнд улсын хэмжээнд боловсролын системд нэвтрүүлсэн.

Сара Назарбаев хөтөлбөрийг санаачлах болсон шалтгааныг “Нэг үе бид хүүхдийн хүмүүжлийн талаар ярихад компьютер эзэмшиж сурах, англи хэлээр ярьж сурах зэргийг хүүхэд хүмүүжүүлэх гол зорилго болгодог байв. Үүний үр дүнд зарим талаар сэтгэл эмзэглэмээр байдалд хүрсэн. Хүүхдүүд маань өсч том болоод сайн сайхныг саар муугаас ялгах чадваргүй, ойр дотно хүмүүсийнхээ жаргал зовлонг хуваалцах сэтгэлгүй нэгэн болж төлөвшиж байна. Хүүхэд багаасаа эрүүл саруул, аз жаргалтай амьдрахын зэрэгцээ амьдралын мэргэн ухаанд суралцах, бусдад туслахын сайн сайхныг ойлгодог байгаасай. Мөн өөрийгөө хэн болох, юуны төлөө амьдарч буй, юуны төлөө зүтгэж байгааг ойлгоосой гэж хүсдэг. Хүн бүр өөрийгөө нээж харуулах нь чухал юм.

Анх “Бөбек” төвийг байгуулахдаа өнчин хүүхдүүдэд туслах зорилгоор юуны түрүүнд эрүүл мэндийн байгууллагуудтай нягт холбоотой ажилласан. Тэднийг хувцас хунар, эм тариа, хоол хүнсээр хангах зорилготой ажилласан боловч энэ нь асуудлыг шийдэх сайн арга биш болохыг ойлгосон юм. Эцэст нь асуудлыг бий болгож буй шалтгаантай тэмцэхээр шийдсэн. Тиймээс боловсролын салбарт шинжлэх ухааны үндэстэй сурах бичгүүдийг зохиож, боловсролын системд нэвтрүүлэх шинэ хөтөлбөрийг өргөн барьж байна” хэмээн илэрхийлсэн.<sup>76</sup>

Энд бидний гол алдаа хүүхдийн мэдлэг боловсролд түлхүү анхаараад хүмүүжлийн асуудлыг орхигдуулсан ба түүнээс үүсэх ирээдүйн үр дагаврыг онцлон хэлжээ. Хүнд ямар нэг зүйл өгч халамжаар тэтгэх биш, мэдлэг боловсролоор тэтгэж, хүний өөрт буй нөөц бололцоо, чадварыг хөгжүүлэх нь чухал юм.

**Хөтөлбөрийн зорилго** нь хүний дотоод ертөнцийг нээснээр зөв боловсон хүн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, эрхэм дээд чанарт сургах, амьдрах чадвар болон боломжийг хөгжүүлэхэд оршино. Түүнчлэн бодол санаа, үг яриа, үйл хөдлөлөө зөв уялдуулах, ямар ч асуудлыг өөрийн болон бусдын тусын тулд оновчтой шийдэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, хүний эрхийг хүндэтгэх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

<sup>76</sup><http://bobek.kz>

“Өөрийгөө таних” хөтөлбөрийн гол санаа нь хүүхэд, залуучуудыг ёс суртахуунтай байх эрхэм чанараа хадгалахад сургахаас гадна үндэстэн бүрийн, хүн бүрийн хамгийн сайн сайхан, гэгээлэг, ариун чанарыг улам хөгжүүлэхэд оршино.

Хөтөлбөрийг Казахстан Улсын боловсролын системд нэвтрүүлснээр “Өөрийгөө таних” хичээлийн хөтөлбөр бий болж, 2010 оны 9-р сарын 1-нээс улсын хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн. Хичээлийн агуулга нь хүний мөн чанарт тулгуурласан бөгөөд өөрийн эрхэм чанарыг мэдрэх, өөрийгөө хүндэтгэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээг ойлгуулан хүмүүжүүлэхийн зэрэгцээ амьдралд зүг чигээ зөв тодорхойлох, шийдвэр гаргах, хариуцлагаа ухамсарлах чадварыг хөгжүүлэхэд оршино. Цэцэрлэг, сургууль, коллежийн хувьд суралцагчдад зөв боловсон хүмүүжил олгох нь нэн тэргүүний асуудлын нэг байдаг. Тийм учраас уг хичээл нь сургуулийн мэдлэгийн талбарт гол үүрэг гүйцэтгэж байна.

2010 оноос хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд сургууль, коллеж, сурган хүмүүжүүлэх ухааны их дээд сургуулиудад “Өөрийгөө таних” хичээл орж эхэлсэн.

Хөтөлбөрийг анх туршилтын журмаар хэрэгжүүлж эхлэхдээ Казахстаны бүс болгонд зарим боловсролын байгууллагад нэвтрүүлсэн. Тэдгээр байгууллагад сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад халуун дотно, итгэл дүүрэн, бүтээлч сэтгэлгээгээр хандах, таатай уур амьсгал бүрдүүлэх, эерэг арга барилаар ажиллах зэрэг шаардлагууд тавигдсан.

“Бөбек”<sup>77</sup> төв нь тэдгээр туршилтын байгууллагын үйл ажиллагааг дэмжин, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан. Өөрөөр хэлбэл, “Өөрийгөө таних” хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, сургалт зохион байгуулах, бүсийн, улсын, олон улсын хэмжээний боловсролын форум зохион байгуулах, эцэг эхчүүдийн сурган хүмүүжүүлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Энэ бүхний үр дүнд сурган хүмүүжүүлэх туршлага хуримтлуулах, туршлага судлах, улмаар хамгийн тохиромжтой туршлагыг сонгож цаашид хэрэгжүүлэх ач холбогдолтой. Мөн туршлага солилцох зорилгоор мэргэжил арга зүйн хүрээнд «Самопознание.KZ» сэтгүүл гаргаж, [www.ozin-ozu-tanu.kz](http://www.ozin-ozu-tanu.kz) интернэт сайт ажиллуулж байна.

<sup>77</sup>“Бөбек” нь Үндэсний шинжлэх ухаан-практик, боловсрол, эрүүл мэндийн төв бөгөөд 1995 онд Ерөнхийлөгч Назарбаевын санаачилгаар байгуулагдсан, 1997 оноос Сара Назарбаев тэргүүлж буй, Бүгд Найрамдах Казахстан Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.



**Хүүхэд залууст хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролыг  
хэдэн наснаас, ямар түвшинд, хэрхэн олгох талаар**

“Өөрийгөө таних” хөтөлбөрийг боловсролын бүх түвшний байгууллагад хэрэгжүүлдэг бөгөөд хүүхдийн насны онцлогт тохируулж “Өөрийгөө таних” хичээлийн хөтөлбөрийг боловсруулсан байна.

**Сургуулийн өмнөх боловсролын түвшинд<sup>78</sup>**

“Өөрийгөө таних” болон “Бөбек” хөтөлбөрүүдийн хүрээнд 2009 оноос “Өөрийгөө таних” тусгай цэцэрлэгүүд ажиллаж эхэлсэн. Зорилго нь хүүхдийг бүх талаар цогц хөгжүүлэх бөгөөд хүүхдэд зориулсан аливаа үйл ажиллагаанд хүний үнэт зүйлсийн талаарх ойлголтыг ухаж ойлгуулах, хүүхдийн өөрийгөө таних болон өөрийн чадварыг мэдэрч ойлгох чадамжийг идэвхжүүлэн хөгжүүлэхэд оршино. Уг цэцэрлэг нь хүүхдэд мэдлэг боловсрол олгох, хүүхдийг хүмүүжүүлэх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах ба чийрэгжүүлэх зэрэг цогц сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг “Өөрийгөө таних” хөтөлбөртэй уялдуулан явуулах боломжоор бүрэн хангагдсан. Цэцэрлэгийн багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эх, хүүхдүүдэд чиглэсэн бүх үйл ажиллагааг “Өөрийгөө таних” хөтөлбөртэй уялдуулж явуулдаг.

Сургуулийн өмнөх насны хүүхдийг сурган хүмүүжүүлэх хичээлийн хөтөлбөрийн агуулга нь хүүхдийн байнгын өдөр тутам хийдэг гол үйлдэл буюу тоглох үйлдлээр дамжуулан мэдлэг боловсрол олгох, төлөвшүүлэн хүмүүжүүлэхэд чиглэсэн.

Түүнээс гадна хичээлийн хөтөлбөртэй уялдуулсан нэмэлт боловсрол олгох зорилгоор дараах хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны хүүхдэд англи хэлний мэдлэг олгох;
- “Сайхан сэтгэлт дельфин” усан сэлэлт;
- “Бяцхан гоц ухаантан” шатрын сургалт;
- “Аз жаргалын жигүүр” театрын студи;
- “Тэмүүлэл” урлагийн студи;
- “Байгаль орчныг чин сэтгэлээсээ хайрла” экологийн клуб;
- “Бяцхан од судлаач” одон орны клуб зэрэг болно.

Цэцэрлэгт улсын тэргүүний шилдэг багш нар ажиллаж, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

“Өөрийгөө таних” цэцэрлэгт хүүхдийг зөв боловсон сурган хүмүүжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагаанд эцэг эхийн үүрэг, оролцоо нэн чухал үүрэгтэй. Эцэг эхтэй хамтран ажиллах зорилгоор “Нээлттэй хаалга” буюу эцэг эхэд зориулсан өдөрлөгийг тогтмол зохион байгуулдаг. Уг арга хэмжээ нь хүүхдүүд хайр халамжтай, сайхан сэтгэлтэй байх, мөн бусадтай харилцан ойлголцоход хэрхэн суралцан хүмүүжиж буйг эцэг эхчүүдэд харуулах зорилготой.

<sup>78</sup><http://character.org/uploads>

“Өөрийгөө таних” хөтөлбөрийг сургуулийн өмнөх боловсролд хэрэгжүүлснээр хүүхдүүд хүнлэг зан чанарын тухай ойлголт авч, сайн сайхан үйл хийж сурахын зэрэгцээ аливаа зүйлд ухамсартай хандаж сурах юм.

### **Бага, дунд боловсролын түвшинд**

Өөрийгөө таних замаар мэдлэг боловсрол олгохын зорилго нь суралцагчийн үнэт зүйл, зөв дадал зуршлыг хөгжүүлэх, өөртөө хандах болон хүрээлэн буй орчинтой, хүн төрөлхтөнтэй харьцах хандлагыг, улмаар хүнлэг зан чанар, нийгэмд ач тустай хандлагыг хэвшүүлэх, өөрийн сонирхлыг нээх, амьдралын зорилгыг тодорхойлох, хүнлэг сонголт хийх, мөн хэлсэн үг болон үйлдэлдээ хариуцлагатай байхыг төлөвшүүлэхэд оршино.

Хичээлийн агуулгыг хүний үнэт зүйлд үндэслэн боловсруулсан бөгөөд дараах агуулгын хүрээнд боловсрол олгох юм. Үүнд:

- хайр сэтгэл, эрүүл мэнд, эрх чөлөө, аз жаргал, хөдөлмөр, бие болон сэтгэлийн уялдаа холбоо, амьдралын зорилго, хүний үүрэг хариуцлага, мөн санаа бодол, үг яриа, үйл хөдлөлийн уялдаа холбоог бүрэн гүйцэд ойлгуулах замаар өөрийгөө таних;
- гэр бүл, найз нөхөд, хүндэтгэл, эрх тэгш байдал, халуун дотно харьцаа, харилцан ярилцах, харилцан ойлголцох, эв найрамдалтай байхын утга учрыг бүрэн гүйцэд ойлгуулах замаар бусдыг таних;
- байгаль орчин, эх орон, дэлхий ертөнц, амьдрал болон бүхэл ертөнцтэй уялдан зохицох, итгэл найдвар зэрэг ойлголтыг бүрэн гүйцэд авснаар хорвоо ертөнцийг таних;
- шударга үнэн, бүтээлч байдал, соёл урлаг, хүн төрөлхтний эв нэгдэл, “хүн төрөлхтөн эх дэлхий хэмээх нэгэн дээвэр дор хамт амьдардаг”-ийг бүрэн гүйцэд ойлгуулах замаар хүн төрөлхтний оюуны бүтээл, мэдлэг туршлагын талаар таньж мэдэх юм.

Бага дунд боловсролын түвшинд боловсруулсан хичээлийн хөтөлбөр нь хүний үнэт зүйлсийн тухай үндсэн ойлголтуудыг хөгжүүлэхэд тасралтгүй байдлыг хангах буюу дэс дараатай мэдлэг олгоход чиглэсэн.

Хичээлийн хөтөлбөр нь “*өөрийгөө таних*”, “*нийгэм дэх хүн*”, “*хүн ба хүрээлэн буй орчин*”, “*хүн төрөлхтний оюуны бүтээл, мэдлэг туршлага*” гэсэн 4 хэсгээс бүрддэг. Бага, дунд боловсролын сургуулиудад эдгээрийн нэршил өөр байж болох ч агуулгыг хэвээр хадгална.

“Өөрийгөө таних” буюу нэгдүгээр хэсэгт сурагчид “хүний дотоод ертөнц”, “хүнлэг сонголт хийх” зэрэг ойлголтуудыг эзэмшсэнээр өөрийгөө таних үндсэн ойлголтыг авах, амьдралын зорилго, үүрэг хариуцлагын талаар ухамсарлаж бусдад туслахын утга учрыг ойлгож эхэлнэ.

“Нийгэм дэх хүн” буюу хоёрдугаар хэсгийн зорилго нь сурагчдын зан чанарыг төлөвшүүлэн хүмүүжүүлэх, түүний зэрэгцээ хөдөлмөрч, сахилга бат сайтай,

хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх, үг яриа болон үйл хөдлөл уялдаа холбоотой нэгдмэл байхын утга учрыг ойлгуулахад оршино. Энэ хэсгийн сэдвүүд сурагчдад бодол санаа үйлдлийн харилцан хамаарлыг ойлгуулах, мөн өөрийгөө таних, өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээг таниулахад чиглэсэн.

“Хүн ба хүрээлэн буй орчин” буюу гуравдугаар хэсгийн агуулга нь орчин тойронтой харьцахад ёс зүйн хэм хэмжээтэй байхын утга учрыг ойлгуулах, гэр бүлээ гэх хайр халамж, хамт олон, найз нөхөд, бусад хүмүүст хүндэтгэлтэй хандах, бусдад итгэх болон бусдын итгэлийг даах чадварыг төлөвшүүлэх зорилготой. Мөн сурагчид анги болон гэр орондоо тэгш эрх эдлэх, түүнчлэн халуун дулаан уур амьсгал бүрдүүлж, тэдний нийгмийн идэвхийг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарна.

“Хүн төрөлхтний оюуны бүтээл, мэдлэг туршлага” буюу дөрөвдүгээр хэсэг нь сурагчдад хүрээлэн буй ертөнцийн гоо сайхан, мөн бүх улс үндэстний урлаг соёлын өв уламжлалд шингэсэн үнэнч байдал, тусч чанар, хайр халамж, шударга ёс зэрэг эерэг сайхан үзэл санааг ухамсарлаж ойлгуулахыг зорьсон. Энэ хэсгийн сэдвүүд нь улс орнуудын урлаг соёл, түүх, ёс заншлыг хүндэтгэх, хүн төрөлхтний эв нэгдлийн талаар ойлгуулах зорилготой. Жишээ нь: агуу хүмүүсийн амьдралыг танилцуулснаар сурагчид хүн хүрээлэн буй орчинтойгоо хэрхэн зохицох талаарх ойлголтыг эзэмших юм.

“Өөрийгөө таних” хичээлийн давуу талуудын нэг нь түүнийг заах явцад сургалтын зарим онцлог арга барилыг хэрэглэдэгт оршино. Тухайлбал, хичээл орж эхлэх болон дуусах үед таатай сэтгэгдэл төрүүлэх, онцолж хэлбэл, “Зүрхнээс зүрхэнд” арга барил нь сурагчийн хичээлд оролцох идэвхийг нэмэгдүүлж, хамт олондоо өөрийгөө нээж харуулах болон хамт олноо эерэгээр хүлээж авах боломж бүрдүүлдэг.

### **Коллеж, их, дээд боловсролын түвшинд**

“Өөрийгөө таних” хөтөлбөрийн хүрээнд түүхэнд нэрээ мөнхөлсөн эрдэмтэн мэргэдийн амьдрал, тэдний хэлсэн сургаал үгсийн мөн чанарыг таниулах замаар суралцагчийн дотоод ертөнцийг нээхийг зорьдог. Ингэснээр нийгмийн өмнө хариуцлагаа ухамсарладаг, идэвхтэй, бүтээлч, хүнлэг, хөдөлмөрч хойч үеийг төлөвшүүлэх юм.

Жишээлбэл: “Есик” коллежид нийгмийн ухааны чиглэлээр суралцаж буй оюутнуудад ёс суртахуун, хүмүүжлийн боловсрол олгодог хичээлийн хөтөлбөрийг “Өөрийгөө таних” хөтөлбөрийн агуулгатай нийцүүлж боловсруулсан.<sup>79</sup>

<sup>79</sup><http://www.balakkk.kz>

«Өзін-өзі тану» рухани-адамгершілік білім берудің жаңартылған бағдарламасын техникалық және кәсіптік білім беру мекемелерінде оқыту ерекшеліктері

Хичээлийн хөтөлбөрийн зорилго:

- Оюутнуудын дотоод ертөнцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Зан чанарыг нь төлөвшүүлэх, өөрөөр хэлбэл, хариуцлага, нэр төр, төлөв даруу зэрэг хүнлэг чанаруудыг төлөвшүүлэх;
- Сурч мэдсэн зүйлийг амьдралд хэрэгжүүлж хэвшүүлэх;
- Хүн болон хүрээлэн буй орчинд сайн үйл хийхийг сургаснаар ирээдүйд ажил мэргэжилдээ дуртай, бүтээлч боловсон хүчнийг бэлтгэх, тэдний мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зэрэг болно.

Хичээлийн хөтөлбөрт буй гол онцлог нь хүмүүжлийн асуудлыг мэдлэг боловсрол олгохоос чухалд тавьсан бөгөөд мэдлэг боловсролыг хүмүүжил дотор багтаасан. Өөрөөр хэлбэл, боловсрол олгох нь хүмүүжлийн нэг асуудал юм. Хичээлийн хөтөлбөрийн агуулга нь хүний үнэт зүйлсийг нээх зорилготой. Түүнчлэн хувь хүнийг төлөвшүүлэх бус төгс хүнийг хүмүүжүүлэх бөгөөд суралцагч бүрийн өөрт буй нөөц боломжийг нээх, хүнлэг чанар болон бүтээлч чанарыг төлөвшүүлэх, бодол санаа, үг яриа, үйл хөдлөл нь уялдаа холбоотой, зан төлөв тэгширсэн зөв боловсон хүнийг төлөвшүүлэн хүмүүжүүлэхэд оршино. Мөнхийн үнэт зүйлсийн талаар ойлгуулж, өөрийгөө таних, нийгэмд сайн сайхан ажиллаж амьдрах боломжийг нээх юм.

Суралцагчийн идэвхийг нэмэгдүүлэх, мэдлэг боловсрол болон хүмүүжил төлөвшлийг хүртээмжтэй олгох үүднээс сургалтын онцлог арга барилуудыг хэрэглэж байна. Үүнд:

- Сайхан сэтгэгдэл төрүүлэх: Хичээл орж эхлэх болон дуусахад сэтгэл ханамжтай байх, сэтгэл санаа тайван байх;
- Хичээлийн ишлэл: Зөв зүйтэй санал бодол, шүүмжлэлийн талаар авч үзэх;
- Яриа хэлэлцүүлэг өрнүүлэх: Хүмүүжлийн ач холбогдолтой сэдвээр яриа хийх;
- Бүтээлч ажил, багаар ажиллах: Ач холбогдолтой тоглоом тоглох, жүжигчилсэн тоглолт хийх, зураг зурах, шүлэг зохиох, эссе бичих, дуу зохиох гэх мэт;
- Хөгжимтэй болон хороор дуулах: Багаар ажиллаж сурах, эв нэгдэлтэй байх зэрэг болно.

Хичээлийн хөтөлбөр нь “Далайн гүнээс шүр, сувд түүх”, “Оюуны мэлмийг нээх”, “Сайн сайханд хөтлөх зам”, “Мэргэн ухаант хүн өөрийн ертөнцийг зөв тодорхойлно” гэсэн 4 хэсгээс бүрддэг.

“Далайн гүнээс шүр, сувд түүх” буюу нэгдүгээр хэсэгт ёс суртахуун, хүмүүжил, төлөвшлийн боловсролыг суут эрдэмтэн багш нарын мэдлэг туршлагад тулгуурлаж олгох ба суралцагчийн хүн төрөлхтний оюуны өв уламжлалд хүндэтгэлтэй хандах сэтгэлгээг хөгжүүлэх юм. Тухайлбал: Сократ, Платон, Аль-Фараби, Баласагун, Абай, Шакарим зэрэг агуу эрдэмтдийн түүх, амьдралын гоц ухаан, гайхамшигт мэдлэг боловсролыг судалснаар суралцагчийн идэвхийг өдөөх хөшүүрэг болохоос гадна үлгэр жишээ болно.

“Оюуны мэлмийг нээх” буюу хоёрдугаар хэсэг нь “Өөрийгөө таних” хичээлийн гол хэсэг болох хүн төрөлхтний мөнхийн үнэт зүйлийн талаар ойлголт олгоно. Үүнд: шударга үнэн, хайр халамж, зөв үйлдэл, эв найрамдал, тайван байдал, амар амгалан, хорон муу зүйл хийхгүй байх гэх мэт. Эдгээр ойлголтыг эзэмшсэнээр эрхэм дээд чанарыг төлөвшүүлэх юм.

“Сайн сайханд хөтлөх зам” буюу гуравдугаар хэсгийн агуулга нь хувь хүний ёс суртахуун, хүмүүжил төлөвшлийг хөгжүүлэх замаар зөв боловсон байх, амьдралаа ухамсартай төлөвлөхөд нөлөөлөх, дээд “Би” хүнийг мэдэрч ойлгуулахад оршино.

“Мэргэн ухаант хүн өөрийн ертөнцийг зөв тодорхойлно” буюу дөрөвдүгээр хэсэгт хүн төрөлхтний үнэт зүйлсээр үүсч, амьдралын туршлагаар өвлөгдөн ирсэн хүнлэг чанаруудын талаар авч үзнэ. Ёс суртахуун, хүмүүжил төлөвшлөөр боловсорч, бодол санаа нь тэгшрэх бөгөөд ингэснээр түр үнэт зүйл болон мөнхийн үнэт зүйл, үнэн ба худлыг ялгах чадвартай болно. Мөн өөрөө амар амгаланг олж, бусдад сайн үйл хийх чадварыг олж авах юм.

“Өөрийгөө таних” хөтөлбөрт тусгасан чухал асуудлын нэг нь багш нарын үүрэг оролцоо юм. Ёс зүй, хүмүүжил төлөвшлийн боловсрол олгоход хүний эрхэм чанаруудыг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлж, хэвшүүлснээр үр дүнд хүрдэг. Үүнд багшийн үүрэг оролцоо чухал ач холбогдолтой. Багшийн хандлага зөв байвал сурагчид нь зөв төлөвших юм.

Бодол санаа, үг яриа, үйл хөдлөл хоорондоо уялдсан хүнлэг сайхан сэтгэлтэй, төгс хүнийг төлөвшүүлэх нь өнөөдрийн нийгэмд тулгарч буй гол асуудлын нэг юм.

“Өөрийгөө таних” хичээлийн давуу талуудын нэг нь түүнийг заах явцад сургалтын зарим онцлог арга барилыг хэрэглэдэгт оршино. Энэ нь хичээл орж эхлэх болон дуусах үед таатай сэтгэгдэл төрүүлэх, сэтгэл ханамж авах, улмаар сурагчийн хичээлд оролцох идэвхийг нэмэгдүүлж, хамт олондоо өөрийгөө нээж харуулах болон хамт олноо эерэгээр хүлээж авах боломж бүрдүүлдэг.

Хөтөлбөрт тусгасан зайлшгүй чухал асуудлын нэг нь багш нарын үүрэг оролцоо болон мэдлэг боловсрол, сурган хүмүүжүүлэх арга зүйг хөгжүүлэхэд анхаарсан. Ёс зүй, хүмүүжил төлөвшлийн боловсрол олгоход хүний эрхэм чанаруудыг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлж, хэвшүүлснээр үр дүнд хүрдэг. Үүнд багшийн үүрэг оролцоо чухал ач холбогдолтой. Багшийн хандлага зөв байвал сурагчид нь зөв төлөвших юм.

“Өөрийгөө таних” хөтөлбөрийн сул тал нь хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдийн асуудлыг онцлон тодорхойлоогүй байна.

Хөтөлбөрийн давуу тал нь түүнийг боловсруулахад хамгийн сайн мэдлэг боловсрол, авьяас чадвартай улсын шилдэг тэргүүний эрдэмтэн багш нарын бүрэлдэхүүн ажилласан тул амьдралд илүү ойр, сонирхол татахуйц бөгөөд боловсролын бүх түвшинд хичээл хэлбэрээр хэрэгжүүлдэг тул маш сайн, жигд хүртээмжтэй байна. Зөвхөн “Өөрийгөө таних” хичээлийн хөтөлбөрийг боловсруулаад зогсоогүй сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, сургалт зохион байгуулах, бүсийн, улсын, олон улсын хэмжээний боловсролын форум зохион байгуулах, багш болон эцэг эхчүүдийн сурган хүмүүжүүлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Энэ бүхнээс харахад хүүхдийн мэдлэг боловсролд түлхүү анхаарч, хүмүүжлийн асуудлыг орхигдуулснаар үр хойч маань сайн сайхныг саар муугаас ялгах чадваргүй, ойр дотно хүмүүсийнхээ жаргал зовлонг хуваалцах сэтгэлгүй нэгэн болж төлөвшихөд хүрээд байна. Энэ бол бидний гол алдаа юм.

Хүнд ямар нэг зүйл өгч халамжаар тэтгэх биш, мэдлэг боловсролоор тэтгэж, хүний өөрт буй нөөц бололцоо, чадварыг хөгжүүлэх нь чухал. Улс орны хөгжлийн үндэс суурь нь хүний хөгжил юм.

### **2.3.АНУ**

АНУ-д иргэний болон зан суртахууны боловсрол нь дараах байдлаар үүсэн хөгжиж ирсэн байна.

- 1937 он - Нийгмийн судлалын хөтөлбөр. Нью Йорк нь Нийгмийн судлалын хөтөлбөрийг хянан шалгах ажиллагаа явуулж, судалгааны үр дүнд нийгмийн судлалын хөтөлбөрт зан чанарыг хөгжүүлэхэд чиглэсэн хэсгийг оруулах шаардлагатай гэж дүгнэсэн.
- 1960-1970 он - Академик сургалтыг чухалчилсан үе. Сургууль академик амжилтыг нэгдүгээрт тавьж, зан суртахууны боловсрол хоцрогдсон. Зан суртахууны боловсролыг тусгай хөтөлбөрөөр бус багш олгоно гэж үзсэн.
- 1960-1980 онд Христийн суруулийн хөдөлгөөн. Улсын ерөнхий боловсролын сургалтад академик буюу сурлагын амжилтыг онцлон ач холбогдол өгч, зан суртахууны боловсрол нь уналтад орсон. Христийн буюу шашны сургуулиуд нь зан суртахуун болон шашны сургалтад ач холбогдол өгөн, гүнзгийрүүлсэн сургалт явуулах болсноор элсэгчдийн тоо үлэмж нэмэгдсэн. Дээрхтэй холбоотойгоор улсын сургуулиудад зан суртахууны боловсролыг дахин зааж эхлэх болсон.
- 1968 он - Зан суртахууны боловсролын хөтөлбөр. Сан Антонио хот дахь Зан суртахууны боловсролын хүрээлэн нь “Зан суртахууны боловсролын хөтөлбөр”-ийг боловсруулсан. Тус хөтөлбөр нь АНУ даяар 60000 сургуульд хэрэгжсэн, өргөн хүрээг хамарсан анхны хөтөлбөр юм.
- 1981-1989 он - Ерөнхийлөгч Р.Рейганы үе. Ерөнхийлөгч Р.Рейган нь сургуулиар дамжуулан зан суртахууны боловсролыг хөгжүүлэхийн ач холбогдлыг онцолж, зан суртахууны боловсролын талаарх олон нийтийн мэдлэгийг сайжруулах, улсын сургуулиудад зан суртахууны хөтөлбөр хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж эхэлсэн.
- 1993-2001 он - Ерөнхийлөгч Б.Клинтоны үе. Ерөнхийлөгч Б.Клинтон сургуулийн зан суртахууны боловсролд нэн тэргүүний ач холбогдол өгч, улсын сургуулиудад зан суртахууны боловсролыг олгох, хөгжүүлэхэд олгодог санхүүгийн дэмжлэгийг гурав дахин нэмэгдүүлсэн.
- 2001-2009 он - Ерөнхийлөгч Ж.Бушийн үе. Ерөнхийлөгч Ж.Буш нь мөн адилаар зан суртахууны боловсролыг олгох, хөгжүүлэхэд олгодог санхүүгийн дэмжлэгийг гурав дахин нэмэгдүүлэхийг Конгрессоос хүссэн.
- 2017 он - Зан суртахууны боловсролын бие даасан хөтөлбөр. Өнөөгийн байдлаар Character Counts!, Heartwood Program, Center for the 4th and 5th R's зэрэг бие даасан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэж байна.

АНУ-ын хувьд ерөнхий боловсролын сургуулиудад Character education буюу Зан суртахууны боловсролын хичээлийг заавал судлах хичээлийн тоонд оруулсан болон хөхиүлэн дэмжихээр хуульчилсан 36 (18 ба 18) муж улс байгаа бол 7 муж улс нь хуулиар тогтоогоогүй боловч бусад баримт бичгийн хүрээнд дэмжихээр тогтоосон, 8 муж улс нь дээрхтэй холбоотой ямарваа нэгэн хууль эрх зүйн зохицуулалтгүй байна.

Хүснэгт 8. Зан суртахууны боловсролыг АНУ-д хуульчлан зохицуулсан байдал

<b>Заавал судлахаар хуульчилсан (18)</b>	<b>Хөхиүлэн дэмжихээр хуульчилсан (18)</b>	<b>Бодлогын баримт бичгийн хүрээнд дэмжихээр заасан(7)</b>	<b>Тодорхой зохицуулалтгүй (8)</b>
Alabama	Arizona	Connecticut	District of Columbia
Alaska	Colorado	Hawaii	Idaho
Arkansas	Delaware	Missouri	Massachusetts
California	Iowa	Montana	Nevada
Florida	Kansas	New Jersey	New Hampshire
Georgia	Louisiana	North Dakota	New Mexico
Illinois	Maine	Vermont	Wisconsin
Indiana	Maryland		Wyoming
Kentucky	Michigan		
Nebraska	Minnesota		
New York	Mississippi		
North Carolina	Ohio		
South Carolina	Oklahoma		
South Dakota	Oregon		
Tennessee	Pennsylvania		
Utah	Rhode Island		
Virginia	Texas		
West Virginia	Washington		

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН



Хүснэгт 1. АНУ-ын муж улсуудад character education-той холбоотой зохицуулалтууд

Д/д	Муж улсын нэр	Огноо	Хууль тогтоомжийн нэр	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт
1	Алабама	1995	1975 Code of Alabama, Section 16-6B-2(h); 1995 Accountability Law, Act 95-313	1975 оны Алабама мужийн хуулиар K-12 <sup>80</sup> (цэцэрлэг, ЕБС)-д хамрагдахад өдөр бүр 10 минут Зан суртахууны боловсрол олгохоор тогтоосон. 1995 оны Хариуцлагын тухай хуулиар ЕБС-д зан суртахууны боловсролыг заавал судлахаар тогтоосон. 2005 оноос Спорт оор дамжуулан суралцах нь хөтөлбөрийн хүрээнд тус мужийн 4 дүгээр ангийн сурагч бүр зан суртахуун болон биеийн тамирын хөгжлийн хөтөлбөрт хамрагдахаар тусгасан.	"Боловсролын асуудал хариуцсан төрийн зөвлөл болон орон нутгийн бүх удирдах зөвлөлөөс ... эр зоригтой, эх оронч, иргэний эрх үүргээ ухамсарласан, шударга ёс, эрх тэгш байдлыг эрхэмлэдэг, бусдыг болон өөрийгөө хүндэтгэдэг, нинжин сэтгэлтэй, хүмүүстэй хамтран ажиллах болон өөрийгөө удирдах чадвар, эгэлдэг, өрөвч, тэвчих үзэл, бүтээлч байдал, ур чадвар, тууштай, цаг баримталдаг, цэвэрч нямбай, хүрээлэн буй орчноо хүндэтгэдэг, тэсвэр тэвчээртэй, үнэнч зэрэг зан чанаруудыг төлөвшүүлэхэд чиглэсэн 10 минутаас доошгүй зааварчилгааг зан суртахууны боловсролын цогц хөтөлбөрийн хүрээнд өдөрт бүх ангиудад боловсруулан хэрэгжүүлнэ. (1995 оны Хариуцлагын тухай хууль).
2	Аляска	1998 2006	Alaska Character Education (ACE) Partnership; Alaska Statute Section 14.33.200	Аляска мужид зан суртахууны боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратегийг боловсруулахад Аляскийн Боловсролын яам, Аляскийн сургуулийн зөвлөлүүдийн холбоо, Аляскийн эцэг эх багш нарын холбоо нь хамтран Аляскийн Зан суртахууны боловсролын түншлэлийг (Alaska Character Education Partnership) санхүүжүүлнэ. Аляскийн зан чанарын боловсролын түншлэлийн тусламжтайгаар тус мужид зан суртахууны боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ба "Чанартай сургууль санаачилга" гэх Аляскийн сургуулийн шинэчлэлийн төлөвлөгөөний хүрээнд Аляскийн иргэншил, эрүүл амьдралын хэв маяг, ур чадварын стандарт, мэргэжлийн боловсролыг хөгжүүлэх, олон нийтийн оролцоо, сургуулийн стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргийг тусгасан байна.	(а) 2007 оны 7 дугаар сарын 1-ний дотор сургуулийн дүүрэг бүр аливаа сурагчийг дарамтлах, айлтан сурдуулэх, эсхүл дээрлэхийг хориглосон бодлогын баримт бичгийг баталсан байна. Сургуулийн дүүрэг бүр нь тус бодлогоо эцэг эх, асран хамгаалагч, сурагч, сайн дурын ажилтан, сургуулийн ажилтнуудад танилцуулна. (б) Бодлогын баримт бичгийг тухайн дүүрэг тус бүрийн шийдвэр гаргах процессын дагуу боловсруулж, батлах ба эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн ажилтан, сайн дурын ажилтан, сурагч, захиргаа олон нийтийн төлөөлөгчдийн оролцоог хангах боломжоор бүрдүүлсэн байна. Бодлогын баримт бичигт зан чанарын эерэг үнэт зүйлс, үүнд соёлтой, хүндэтгэлтэй үг хэллэг хэрэглэх, биеэ авч явах байдлын ач холбогдол, сурагчдын зүгээс бие биэндээ дарамт шахалт үзүүлэх, айлтан сурдуулэх, дээрлэхийг хориглосон бодлогыг дагаж мөрдөх үүрэг хариуцлагыг тусгасан байна. Түүнчлэн тус бодлогын баримт бичигт сургуулиас хөөх, гэмт хэргийн талаар орон нутгийн хууль сахиулах байгууллагад мэдээлэх зэрэг холбогдох шийтгэлийн зохицуулалтыг тусгасан. Сургуулийн ажилтан, сайн дурынхан, оюутнууд, сургуулийн захиргаа нь дээрхийг дагаж мөрдөнө.

<sup>80</sup> АНУ-ын ерөнхий боловсролын тогтолцоо нь K-12 буюу цэцэрлэгээс 12-р анги байх ба эдгээрийг Цэцэрлэгээс 5-р ангийг Бага (Elementary), 6-8 дугаар анги хүртэл Дунд (Middle) болон 9-12 ангиуд Ахлах (High) гэсэн дараалалтай байдаг. Энэ ерөнхий бүтэц АНУ-н нийт 50 муж, Вашингтон ДС хотод ажил дагаж мөрдөх боловч сургуульд оюутан элсүүлэх, бүртгэх, шалгалт үнэлгээ нь тухайн муж, улмаар тухайн хотын сургуулийн дүүрэг тус бүрт харилцан адилгүй байж болдог. Өөрөөр хэлбэл, сургуулийн орлого, зардал, боловсон хүчний бодлого, сургуульд хүүхэд сургах журам зэргийг орон нутгийн хүрээнд шийдэх эрхтэй байна.

Д/д	Муж улсын нэр	Огноо	Хууль тогтоомжийн нэр	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт
3	Арканзас	1997	Act 631 of 1997	1997 оны 631 дугаар хуульд заасны дагуу Арканзас мужийн дүүргийн бүх сургуулиудад зан суртахууны боловсролын хичээлийг заавал судлахаар тогтоосон.	Ерөнхий Ассамблей нь зан суртахууны болон иргэний боловсрол, хүмүүжил нь гол төлөв эхлэх хариуцлагад хамаарах асуудал болохыг хүлээн зөвшөөрч буй хэдий ч үүгээр хязгаарлагдахгүй байна. Цаашлан Ерөнхий Ассамблей нь сурэгчдыг нийгмийн амьдралд бэлтгэхэд улсын сургуулиудад зан суртахууны болон иргэний боловсролыг бэхжүүлэх шаардлагатайг тодорхойлсон. Боловсролын яамны Ерөнхий боловсролын газрын захирал нь улсын болон мужийн хэмжээнд иргэний болон зан суртахууны боловсролын асуудлаар үйл ажиллагаа явуулж буй сект бус (шашны гэж урсгал бус) дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломж бүхий төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг орон нутгийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад гаргаж өгнө. Тус газрын захирал нь сект бус төсөл, хөтөлбөр, загваруудын талаарх мэдээллийг тус муж дахь бүх сургуулиудад хүргэх үүрэгтэй байна. ... Захирал нь хоёр жил тутам энэхүү хуулийн хэрэгжилт, үр дүнгийн явцын тайланг гаргаж өгнө.
4	Калифорни	2000	California Education Code Section 233.5(a) [formerly named Section 44806] and Section 44790.3 Assembly Bill 2028 of 2000	Калифорни муж нь Боловсролын хуульдаа зан суртахууны боловсрол олгохыг тусгаж, тухайн мужийн багш бүрт зан суртахууны боловсролын гарын авлагаар хангахаар заасан байна. 2007 оны тогтоолоор тус мужид жил бүрийн 10 дугаар сарыг "Зан суртахууны боловсролын сар" болгон зарласан.	"Багш бүр сурэгчдэд ёс суртахуун, үнэн, шударга ёс, эх оронч үзэл, Америкийн иргэний эрх, үүрэг, бахархлын талаарх үнэн зөв ойлголтыг өгөх, ба эрх тэрш байдал, хүний нэр төр, үндэс зэргийг харилцааг хөгжүүлэх, гэрийн тэжээвэр амьтдыг энэрэх, энэрэнгүй, хүмүүнлэг хандах хандлагыг төлөвшүүлэх, сурэгчдын залуурал, бодүүлэг үг хэл хэрэглэх, худал хуурмагаас хол байхыг зааж сургахыг эрмэлзэнэ. Түүнчлэн багш бүр сурэгчдын өөрсдийн потенциалгаа бүрэн дүүрэн ашиглах, аливаа алагчлал бүхий хандлага, үйлдлээс ангид, үзэн ядах үзэл дээр суурилсан хүчирхийлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн орчныг бүрдүүлэхийг эрмэлзэнэ..." (Калифорны Боловсролын Кодын 233.5 (а) хэсэг) "Хууль тогтоох байгууллага нь Калифорнийн сургуулиудад (1-12-р анги), сургуулийн өмнөх боловсрол ёс зүй, иргэний үр дүнтэй боловсролын хөтөлбөрийг хөгжүүлэх, хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжих шаардлагатайг тогтоожээ. (44790.3р хэсэг).

Д/д	Муж улсын нэр	Огноо	Хууль тогтоомжийн нэр	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт
5	Флорида	1999	House Bill 365 of 1999 (Florida Statutes Sections 233.061 and 230.2316 amended)  Senate Bill 20E of 2002	1998 онд Флоридагийн Хууль тогтоох байгууллага нь бага сургуульд зан суртахууны боловсрол олгохоор тогтоосон. 1999 онд хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр зан суртахууны боловсрол нь шашнаас ангид байж, анхаарал халамж, тэвчээр болон санаачилгатай байдал зэрэг зан чанарыг төлөвшүүлэхэд чиглэнэ. Мөн 1999 онд Флоридагийн хуулийн 233.0619-р хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх, академик хоцрогдол арилгахад чиглэсэн бүх хөтөлбөрүүдэд хууль эрхзүйн болон зан суртахууны боловсрол олгохоор тусгасан байна. 2002 онд баталсан Сенатын хуулиар 2004-2005 оны хичээлийн жилээс эхлэн цэцэрлэгээс сургуулийн 1-12-р ангид зан суртахууныг төлөвшүүлэх, хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхээр заасан байна. 1999 онд байгуулагдсан Флорида мужийн зан суртахууны боловсролын зөвлөх хороо нь сургуулиудад дэмжлэг үзүүлнэ.	"Дүүргийн сургуулийн удирдах зөвлөл бүр зан суртахууныг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, эсхүл сонгон авч холбогдох яаманд хүргүүлж, зөвшөөрөл авна. Зан суртахууныг хөгжүүлэх хөтөлбөр нь эх оронч үзэл, үүрэг хариуцлага хүлээдэг, иргэншил, нийжин сэтгэлтэй, хүндлэл, үнэнч шударга зантай, өөрийгөө хянах чадвартай, тэвчээр ба хамтран ажиллах чадвар зэрэг зан чанаруудыг хөгжүүлэхэд чиглэгдэнэ. (Senate Bill 20E of 2002).
6	Жоржиа	1997	Title 20, Chapter 2, Article 6 of the Official Code of Georgia amended with 20-2-145	1997 онд иргэний боловсрол, бусдыг болон өөрийгөө хүндлэх зэрэгт суурилсан нийт 27 зан чанарыг төлөвшүүлэхэд чиглэсэн зан суртахууны боловсролыг Жоржиа мужийн бага, дунд, ахлах сургуулиудын сургалтын хөтөлбөрт оруулахаар хуульд тусгасан байна.	"Мужийн боловсролын удирдах зөвлөл нь 1997-1998 хичээлийн жилд K-12 түвшинд зориулан зан суртахууны боловсролын цогц хөтөлбөрийг боловсруулна. Зан суртахууны боловсролын цогц хөтөлбөр нь суралцдаг эр зориг, эх оронч үзэл, иргэншил, үнэнч шударга байдал, бусдыг хүндлэх, нийжин сэтгэл, хамтран ажиллах, өөрийн хүндлэх, хянах, найрсаг, энэрэнгүй, тэвчих үзэл, хичээнгүй, егөөмөр, цаг баримтлах, цэвэрч нямбай, сэргэлэн цовоо, сургуулийн дэг журмыг сахих, хүрээлэн буй орчныг хүндлэх, Ертөнцийн эзнийг хүндэтгэх, бүтээлч байдал, спортын ур чадвар (sportsmanship), тууштай зэрэг зан чанарыг хөгжүүлэхэд чиглэнэ. Орон нутгийн удирдах зөвлөлүүд нь дээрх хөтөлбөрийг аль ч анги болон хугацаанд хэрэгжүүлэх бол мужийн удирдах зөвлөлүүд нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг дэмжих үүрэгтэй байна. Энэхүү хуульд үл нийцэх бүх хууль болон хуулийн хэсгүүд нь хүчингүй болно." (Official Code of Georgia, Annotated 20-2-145a in 2002)

Д/д	Муж улсын нэр	Огноо	Хууль тогтоомжийн нэр	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт
7	Иллиной	1998	Illinois Children's Mental Health Act of 2003 (Public Act 93-0495, Senate Bill 1951 of 2003); House Bill 1336 of 2005 (amended language originally defined in 1998)	2005 онд Иллиной мужийн хуулиар бүх улсын сургуулиудад зан суртахууны боловсрол олгохоор тогтоосон. 2007 онд АНУ-ын Боловсролын яам болон зан суртахууны боловсролын хөтөлбөрөөс Иллиной мужид зан суртахууны боловсролыг хөгжүүлэхэд 500 000 ам.долларын грантыг 8 ахлах сургуульд сурагчдын цаашдын амьдралд нь шаардагдах ур чадвар, туршлага олгох 4 жилийн туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд олгосон.	"Улсын сургуулийн багш бүр зан суртахууны боловсролыг заах ба үүнд хүндлэл, үрэг хариуцлага, шударга зан, бусдыг халамжлах, итгэл даах чадвар, иргэншил зэргийг заах замаар сурагчдын шударга зан, нинжин сэтгэл, шударга ёс, бусдыг хүндлэх, гэмт хэргийг бууруулах ёс суртахууны эр зориг болон сайн зан чанарыг төлөвшүүлэх стандартыг дээшлүүлэхийг зорино. (House Bill 1336 of 2005). Иллиной муж нь сурагчдын сурах чадвар, гэмт хэрэг, хүчирхийлэл үйлдэх зэрэгт сэтгэцийн эрүүл мэнд ихээхэн нөлөөллийг онцолж, Иллиной мужийн Боловсролын удирдах зөвлөл Иллиной мужийн сургалтын стандартад нийгмийн болон сэтгэл хөдлөлийн хөгжлийн стандартыг боловсруулж, хэрэгжүүлэхийг үүрэг болгов." (Иллиной мужийн хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, 2003)
8	Индиана	1937	Indiana Code 20-10.1-4-4 (Morals Instruction)	1995 онд Индиана мужийн Ерөнхий Ассамблей нь сайн иргэншлийн боловсрол олгохоор хуульчилсан ба үүнд Индиана мужийн иргэнд шаардлагатай 13 зан чанарыг тодорхойлсон байна. Тус хууль нь 1937, 1975 онуудад батлагдаж байсан хуулийн зохицуулалттай ойролцоо ойлголтуудыг дахин баталгаажуулсан. Энэхүү хуулийг хэрэгжүүлэхийн тулд Индиана мужийн Боловсролын яам нь 2000 онд Андерсон их сургуультай хамтран зан чанарын хөгжлийн төвийг байгуулж, тус мужийн сургууль болон нийгмийн бүлгүүдэд зан чанарын боловсрол олгоход нь дэмжлэг үзүүлж эхэлсэн байна. Мөн муж нь зан суртахууны боловсрол олгоход оролцож буй бүхий л оролцогч талуудад зориулсан "Сайн иргэншлийн төлөөх түншүүд: Эцэг эх, сургууль, орон нутаг" гарын авлага, зааврыг боловсруулсан байна.	Улсын болон хувийн сургуулийн 1-12-р ангид ерөнхий суурь хичээлд багшлах багш бүр хичээлээ заахдаа үнэнч шударга зан, ёс суртахуун, зөгдөг зан, хууль сахин биелүүлэх, төрийн туг далбаа, АНУ-ын Үндсэн хууль болон муж улсаа дээдлэх, гэр орон болон эцэг эхээ хүндлэх, үнэнч шударгаар хөдөлмөрлөх болон шударга, сайн иргэнийг хөгжүүлэхэд шаардлагатай бусад зан чанарыг хөгжүүлэхэд анхаарна. Мужийн захирагч (The state superintendent) нь дээрхтэй холбоотойгоор 1-12-р ангид заах ерөнхий суурь хичээлүүдэд оруулах материал, зарчмыг боловсруулж, бэлтгэнэ." (Indiana Code 20-10.1-4-4, Morals Instruction. Formerly: Acts 1975, P.L.240, SEC. 1).

Д/д	Муж улсын нэр	Огноо	Хууль тогтоомжийн нэр	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт
9	Кентукки	2000	House Bill 157 of 2000	2000 онд Кентуккигийн багц хуулийн 162-р хэсгийг баталж, 158-р хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулж сургуулийн сургалтын хөтөлбөрт зан суртахууны боловсролын хичээл оруулахаар тогтоосон байна. Дээрх хуулийг баталснаар Кентукки мужийн Боловсролын удирдах зөвлөл нь сургуулиудад зан суртахууны боловсрол олгохтой холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө өгч, сургалтын хөтөлбөртөө оруулахад нь дэмжлэг үзүүлж ажиллана.	"...зан суртахууны боловсрол гэдэг нь суратчдын бусдыг энэрэх сэтгэл, иргэншил, эелдэг зан, хүний үнэ цэнэ, шударга ёс, мэдлэг, хүндэтгэл, хариуцлага, бие даан ажиллах чадвар зэрэг суратчдад эзэмшүүлбэл зохих зан чанар, үнэт зүйлсийг сурталчилсан, тусгасан сургалтын хөтөлбөр, стратеги байх ба эцэг эх, багш, орон нутгийн иргэдийн үнэт зүйлсийг тусгаж, суралцагсдын амьдрал дахь ёс суртахуун, ёс зүйн шийдвэр гаргах чадварыг сайжруулахад чиглэсэн байна." (Chapter 162, Section 1 of KRS. New chapter created in House Bill 157 of 2000).
10	Небраска	1996	Nebraska Statutes, Chapter 79, Sections 725, 726, and 727	1927 онд Небраска муж нь зан суртахууны боловсрол дахь сургуулиудын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон хууль тогтоомжийг анх баталсан. 1996 онд үнэнч шударга, ёс суртахуун, эелдэг, хууль дүрэм сахидаг, төрийн туг далбаа, АНУ-ын Үндсэн хууль болон Небраска муж улсын Үндсэн хуулийг дээдлэх зэрэг хувь хүний зан чанаруудыг Небраскагийн хуулийн 79-725 -д тус мужийн иргэнд байвал зохих зан чанаруудын хэмжээгээр тодорхойлсон байна. Мөн хуульд Небраскагийн Боловсролын Комиссар нь тухайн муж дахь бүх K12 сургуулиудад зан суртахууны боловсрол олгох талаар санал зөвлөмж гаргах ба тус хуулийг хэрэгжүүлээгүй аливаа этгээд нь гэмт зөрчил үйлдсэн болно. (Небраска мужийн зан суртахууны боловсролын удирдамжийг дараах хаягаар орж үзнэ үү <a href="http://www.nlc.state.ne.us/erubs/E2000/H091-2002.pdf">http://www.nlc.state.ne.us/erubs/E2000/H091-2002.pdf</a> )	Небраска мужийн улсын, хувийн, сүм хийдийн дэргэдэх (parochial), эсхүл шашны боловсрол олгох (denominational) сургуульд багшлах багш нь үнэнч, шударга, ёс суртахуун, эелдэг, хууль дүрэм сахин биелүүлдэг, төрийн туг далбаа, АНУ-ын Үндсэн хууль болон Небраска мужийн Үндсэн хуулийг дээдлэх, гэр орон болон эцэг эхээ хүндлэх, үнэнч шударгаар хөдөлмөрлөх болон шударга, сайн иргэнийг хөгжүүлэхэд шаардлагатай бусад зан чанарыг хөгжүүлэхэд анхаарна. (Nebraska Statutes, Chapter 79, Section 725).

Д/д	Муж улсын нэр	Огноо	Хууль тогтоомжийн нэр	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт
11	Нью Йорк	2000	Project SAVE (Safe Schools Against Violence in Education Act)	2000 онд Нью Йоркийн Ассамблей нь Боловсрол дахь хүчирхийллийн эсрэг Аюулгүй сургуулиудын тухай хууль (SAVE) хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн ба хөтөлбөрт сургуулийн орчинд биеэ авч явах ёс зүйн дүрэм, сургуулиудын аюулгүй байдлын төлөвлөгөө, хүчирхийллийн талаар мэдээлэх нэгдсэн тогтолцоо, сургуулийн албан хаагчдыг хамгаалах, сургуульд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр болон эелдэг найрсаг байдал, иргэншил, зан суртахууны боловсрол олгох зэргийг багтаасан байна.	Нью Йоркийн сургуулиуд нь хүнд хэцүү болон хүч хэрэглэж буй тохиолдлуудыг таслан зогсоох, зохицуулах цогц төлөвлөгөөг боловсруулж, орон нутагт гарч болзошгүй хүчирхийллийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд орон нутгийн түншүүдтэй хамтран ажиллаж, сургуулийн орчинд хүндэтгэл, хариуцлагыг дээдэлсэн орчныг бүрдүүлэхэд эелдэг найрсаг байдал, иргэншил, зан суртахууны боловсролын хөтөлбөрийг боловсруулах ... дээрх нь сурагчдад үнэнч, тэвчиг үзэл, хувийн хариуцлага, бусдыг хүндэтгэх, хууль дүрэм сахин биелүүлэх, эелдэг, нийгэмд хувь нэмэр оруулах, өөрсдийн зан чанарт эерэгээр нөлөөлөхөд чиглэгдсэн байна. (Project SAVE, 2000).
12	Хойд Каролина	2001	Student Citizen Act of 2001 (House Bill 195 of 2001)	Сурагч иргэний тухай хуулийг 2001 (SL 2001-363) онд Хойд Каролина мужийн хууль тогтоох байгууллага баталсан ба орон нутгийн боловсролын удирдах зөвлөл бүр зан чанарын сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхээр тогтоосон байна.	Сургалтыг хичээлийн хөтөлбөрт оруулан дараах зан чанарыг хөгжүүлэхэд чиглэсэн байна. Үүнд: эр зориг (бусад нь хийхгүй байсан ч зөв зүйлийг хийх эр зоригтой байх, бусдыг дагах бус өөрийн ухамсраа дагах, хүнд хэцүү боловч үр дүнтэй зүйлийг хийхийг эрмэлзэх); эрүүл сэтгэлгээ/good judgement (зөв, зохистой зорилго сонгож, чухал зүйлсийн эрэмбэ дарааг зөв тогтоох, үйлдлийнхээ үр дагаврын талаар бодож тунгаах, мэргэн ухааныг үндэслэн гаргах); шударга зан (бүх зүйлд үнэнч, итгэл даах чадвартай, шударга байх дотоод хүч чадалтай байх, шударга, нэр хүндтэй байх); нинжин сэтгэл (бусдыг бодож, эелдэг, тусч, бусдыг ойлгох, бусдыг энэрч, нигүүлсэх, нөхөрлөл, өгөөмөр сэтгэл, өөртэй нь хэрхэн харьцахыг хүсэж буй байдлаар бусадтай харьцах); тууштай байх (хүнд хэцүү үл харгалзан тавьсан зорилгодоо тууштай байх, алдаа, дутагдал гаргасан тохиолдолд тэсвэр тэвчээртэй байж, үргэлжлүүлж, дахин оролдох) ... (The Student Citizen Act of 2001).



Д/д	Муж улсын нэр	Огноо	Хууль тогтоомжийн нэр	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт
13	Өмнөд Каролина	2000	South Carolina Code, Section 59-17-135 (Amended from 1976 Code)	1996 онд мужийн Боловсролын яам нь зан чанарын урт хугацааны хөтөлбөр боловсруулах, дэд бүтцийг бий болгоход 4 жилийн хугацаатай буцалтгүй тэтгэлэг авсан ба 2000 онд Өмнөд Каролина мужийн Ерөнхий Ассамблей нь Гэр бүл-хүндлэлийн тухай хуулийг баталж, Боловсролын яаманд зан суртахууны боловсролын хөтөлбөрт зориулан 265,000 ам.доллар олгосон байна. Хуульд заасны дагуу сургууль бүр зан чанарын боловсролын хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөр болон түүний хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэж байхаар тусгасан. Өмнөд Каролинагийн боловсрол болон эдийн засгийн хөгжлийн тухай хуулиар Өмнөд Каролинагийн хуулийн 59-17-135-д нэмэлт, өөрчлөлт оруулан зан суртахууны боловсролд тусгавал зохих 24 зан чанарыг тогтоосон байна.	Муж улсын сургуулийн итгэмжлэгчдийн зөвлөл бүр нь зан суртахууны боловсролын асуудлаар бодлого боловсруулж, тус бодлогын үндсэн дээр хэрэгжүүлж буй зан суртахууны боловсролын хөтөлбөр нь дараах зан чанаруудыг тусгасан байна. Үүнд: удирдлага болон бусдыг хүндлэх, үнэнч, өөрийгөө удирдах чадвар, цэвэрч нямбай, эелдэг, бусадтай хамтран ажиллах, иргэншил, эх оронч үзэл, эр зориг, шударга, нинжин сэтгэл, өөрийгөө хүндлэх, энэрэх, хичээнгүй, ажил хөдөлмөрийн ёс зүй, хичээл сургалтын зөв дадал зуршил, өгөөмөр, цаг баримталдаг, урам зоригтой, тэвчээртэй, спортын ур чадвар (sportsmanship) ба сайн үйл хэрэг зэрэг байна. Сургуулийн удирдах зөвлөлүүд нь зан суртахууны боловсролын бодлого, хөтөлбөр боловсруулахдаа нийгмийн бүлгүүдийн бүхийл төлөөллүүдийг оролцуулна. (South Carolina Code, Section 59-17-135)
14	Өмнөд Дакота	1997	South Dakota Legislative Statute, 13-33-6.1	2001 онд Өмнөд Дакотогийн Боловсролын яам нь зан суртахууны боловсролын хөтөлбөр боловсруулахад холбооны грант хүлээн авсан ба нийт 10 сургуулийн сонгон авч, туршилтын хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн байна. Тэтгэлэг олгосон гол зорилго нь Өмнөд Дакотогийн хууль дүрэмд заасан чанаруудыг агуулсан сайн чанарын зан чанарын сургалтыг бий болгох.	Удирдах байгууллага нь нэгээс доошгүй, эсхүл дөрвөөс дээш хичээлийн улиралд өөрөөр тогтоосноос бусад тохиолдолд мужийн улсын болон хувийн бүх бага, дунд сургуулиудад зан чанарын сургалт явуулах ба сурагчдад иргэншил, эх оронч үзэл, үнэнч байдал, хувийн сахилга бат, өөрийгөө хүндлэх, бэлгийн харьцаанд орохгүй байх, Өмнөд Дакота мужид үндэстэн ястнуудын оруулсан хувь нэмрийг хүндлэх, ахмад болон удирдлагыг хүндлэх зэргийн чухлыг ойлгуулахад чиглэгдэнэ. South Dakota Legislative Statute, 13-33-6.1



Д/д	Муж улсын нэр	Огноо	Хууль тогтоомжийн нэр	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт
15	Теннесси	1985	Tennessee Code Annotated (TCA), Sections 49-6-1007 and 49-2-118;  House Bill 3456 of 2004/Public Chapter Number 919;  House Bill 2790 of 2008	1985 онд Теннессийн Ерөнхий Ассамблей TCA 49-6-1007-г баталсан ба хуульд заасны дагуу улсын бүх сургуулиуд нь зан суртахууны боловсрол олгох юм. 1999 онд дээрх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж сургуулиуд нь хэрэгжүүлж буй зан чанарын хөтөлбөрийн талаар мэдээллийг Боловсролын яам болон Ерөнхий Ассамблейд мэдээлж байхаар заасан. 1999 онд TCA 49-2-118-ийг баталсан ба үүгээр 1-6-р ангид зан чанарын сургалтын агуулгад маргаан, зөрчлийг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх асуудлыг тусгахаар зохицуулсан байна. 2004 онд House Bill 3456 (Public Chapter Number 919)-г баталсан ба зан чанарын боловсрол олгож буй арга зүй, сайн туршлагыг түгээхээр тогтоосон. 2008 онд House Bill 2790-г баталсан ба үүгээр улсын бүх K12 сургуулиудад зан чанарын сургалтын агуулгад маргаан, зөрчлийг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх асуудлыг тусгахаар хуульчилсан.	Улсын бүх сургуулиудад сурагч бүрт зэрэг хандлагыг төлөвшүүлэх, зэрэг үнэт зүйлсийг удирдлага болгон сурагчийн хувьд биеэ зөв авч явахад суралцсанаар сайн иргэн болж төлөвшинө. (T.C.A. 49-6-1007).  LEA бүр 1-6-р ангиудад маргаан шийдвэрлэх, сургууль болон сургуулийн орчинд үймээн самуун, хорлон сүйтгэх хандлага гарахаас урьдчилан сэргийлсэн шийдвэр гаргалтын стратеги бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Боловсролын комиссарт жил бүр өмнөх жил хэрэгжүүлсэн маргаан шийдвэрлэх хөтөлбөрийн биелэлтийн тайланг хүргүүлнэ. (TCA, Section 49-2-118).
16	Юта	2004	Utah Code Annotated, Sections 53A-13-101.4 and 53A-13-109;  HCR 7 of 2003;  House Bill 339 of 2006	2002 онд Юта мужийн хууль тогтоох байгууллагаас Ютагийн кодексийн 53A-13-101.4-р хэсгийг баталсан. Хуульд заасны дагуу тус мужийн улсын сургуулиудад АНУ-ын түүх болон улс төрийн (төрийн онол) хичээлийг үр дүнтэй явуулж буй эсэхийг тогтмол хяналт тавих юм. 2003 онд дээрх хөтөлбөрийг иргэний хариуцлага, бусдыг хүндлэхэд чиглэсэн зан чанар, иргэний боловсролоор орлуулсан байна. 2004 онд Ютагийн Ерөнхий чуулганаар Utah Code, Section 53A-13-109-ийг баталсан ба үүнд K-12 нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөрийн хүрээнд иргэний болон зан суртахууны боловсролыг нэмж тусгасан байна.	"Нэгдсэн хичээлийн хөтөлбөрөөр сурагчдад үнэнч шударга, ёс суртахуун, хүнлэг, үүрэг, нэр төр, хууль дүрэм сахин биелүүлэх, Тусгаар тогтнолын тунхаг бичиг болон Үндсэн хууль, Юта муж улс болон түүний хөгжлийн түүхийг ойлгон хүндэтгэх, эцэг эх, гэр орон, гэр бүлээ хүндлэх, шударгаар хөдөлмөрлөх хэрэгцээ, үнэ цэнэ болон сайн, шударга хүн, иргэн болон төлөвшихд шаардлагатай бусад үр чадвар, зуршил, зан чанаруудыг хөгжүүлэх, Үндсэн хуулиар баталгаажсан, өмнөх үеэс уламжилж ирсэн эрх чөлөөг цаашид хадгалж, хамгаалах үүрэг хариуцлагыг ухаамсарлуулах. Улсын сургуулиудад заахаар тусгасан Иргэн болон зан суртахууны боловсролыг энэ хэсэгт заасан ухагдахуун, хүрээнд үр дүнтэй олгоход орон нутгийн сургуулийн удирдах зөвлөл,

Д/д	Муж улсын нэр	Огноо	Хууль тогтоомжийн нэр	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт
17	Виржиния	1999	Code of Virginia, Sections 22.1-208.01, 22.1-201 and 22.1-202;  House Bill 1498 of 2003 (Chapter 777)	2006 онд House Bill 339 нь иргэдийн болон зан суртахууны боловсролын талаар нийтэд мэдээлэх, таниулах зорилго бүхий эвсэл, сургалтуудыг дэмжих зорилготой Ютагийн Иргэний болон зан чанарын боловсролын хороог байгуулсан ба 2006-2007 оны хичээлийн жилд 50 000 ам.Доллар олгосон байна.	удирдлагууд нь шаардлагатай сургалт, удирдамж, дэмжлэг зэргээр хангаж болно.” (Utah Code Annotated, Section 53A-13-109).
				1999 онд Виржиниягийн Ерөнхий Ассамблей нь мужийн кодекс нэмэлт, өөрчлөлт оруулан зан суртахууны боловсрол олгохоор тогтоосон. Тус нэмэлт, өөрчлөлтөөр бусдыг дээрлэх, доромжлохгүй байх зэргийг зааж сургахаар тусгасан. Боловсролын удирдах зөвлөл нь зан суртахууны боловсролд тавигдах шаардлагыг боловсруулж, сургуулиудад нөөцийг хуваарилахаас гадна шинэлэг хөтөлбөр хэрэгжүүлж буй сургуулийн удирдах зөвлөлд буцалтгүй тэтгэлэг зэргийг олгож болно. 2000 онд Виржиниягийн кодексийн 22.1-201-р хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулж, сурагчдад иргэний эрх, үүргийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд Тусгаар тогтнолын тунхаг бичиг, АНУ-ын Үндсэн хууль, Хүний эрхийн хууль (Bill of Rights), Виржиниягийн шашин шүтэх эрх чөлөөний тунхаглал, Виржиниягийн хүний эрхийн тунхаглал зэрэг судлах баримт бичгийн жагсаалтыг баталсан. 2001 онд Виржиниягийн кодексийн 22.1-202-р хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулж, АНУ, Виржиниягийн туг далбааны тухай болон Тугандаа тангараг өргөх ёсны талаар хичээл орохоор тусгасан байна. 2003 онд House Bill 1498 -ээр зан суртахууны боловсролд Виржиниягийн иргэнд шаардлагатай зан чанар, ёс суртахууны хэм хэмжээг тусгаж өгсөн. (Article I, Virginia Constitution).	"Зан суртахууны боловсролын зорилго нь сурагчдын сурах орчныг сайжруулах, сурлага болон сахилга батын асуудлыг дээшлүүлэхэд шаардлагатай зан чанар, ёс суртахууны хэм хэмжээг ухамсарлуулах, зан суртахууны боловсрол олгож, хүмүүжилтэй иргэнийг төлөвшүүлэхэд оршино. Хөтөлбөр тус бүрийг сурагч, эцэг эх, нийгмийн бүлгүүдийн оролцоотойгоор боловсруулна. Зааж сургаал зохих зан чанарын тоонд итгэл даах чадвар, үнэнч шударга байдал, мөрдөж явах "Алтан дүрэм"-ийг дагаж мөрдөх, хүндэтгэлтэй хандах, хүлцэн тэвчих, эелдэг байх, хөдөлмөрч байх, хариуцлагатай хандах, эдийн засгийн хувьд бусдаас хараат бус, өөрийгөө удирдах чадвартай, муу үйлдлийн үр дагаврыг ойлгодог, ялгаварлан гадуурхахгүй байх, бусдыг халамжлах, энэрэл, нигүүлсэх, бусдыг боддог өгөөмөр зан, эх оронч үзэл, АНУ-ын далбааг дээдлэх, Тангарагтаа үнэнч байх, нийтийн сайн сайхны төлөө санаа тавих, хууль дээдлэх зэрэг орно."

(Code of Virginia, Section 22.1-208.01).

Д/д	Муж улсын нэр	Огноо	Хууль тогтоомжийн нэр	Зохицуулалтын тойм агуулга	Хуулийн заалт
18	Баруун Виржиния	2001	1995 State School Act; House Bill 2208 of 2001 (amended West Virginia Code, Section 18-2-13); West Virginia Code, Section 18-2-9	1995 онд батлагдсан Улсын сургуулийн тухай хуулиар Мужийн боловсролын департамент нь долоо хоног бүр орох зан суртахууны боловсрол бүхий сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулна. 2001 онд Баруун Виржиниягийн хууль тогтоох байгууллага нь House Bill 2208 (amended West Virginia Code, Section 18-2-13)-г баталсан ба сургуулийн соёл, үйл ажиллагаа болон хичээлийн хөтөлбөр зэрэгт зан суртахууны боловсролын цогц хөтөлбөрийг оруулахаар мужийн зөвлөлд үүрэг болгосон байна. Түүнчлэн Баруун Виржиниягийн Кодексийн 18-2-9-р хэсэгт зааснаар бүх сурагчид иргэний, АНУ-ын Үндсэн хуулийн, үндэсний болон муж улсын төрийн тогтолцооны талаарх хичээлийг заавал судлахаар заасан байна.	"Мужийн зөвлөл нь цэцэрлэгээс 12-р анги хүртэлх сургалт бүхий бүх сургуулиудад одоо мөрдөж буй хичээлийн хөтөлбөртөө зан суртахууны боловсролын агуулгыг боловсруулж, тусгахаар заасан. Сургуулиуд нь үнэнч шударга, иргэншил, бусдад санаа тавьдаг, сурлагын амжилт, гэрийн даалгавраа хийх, хичээлээ таслахгүй байх, маргаан үүсгэхгүй байх, зайлсхийх, хүч хэрэглэхгүй байх, сургуулийн зэрэг орчин бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах, хичээлд идэвхтэй оролцох, үе тэнгйхэндээ архи, тамхи, мансууруулах бодисыг хэрэглүүлэхгүй байх талаас нь нөлөө үзүүлэх, дээрх бодисын хэрэглээний үр дагаврын талаар мэдлэгтэй болгох, өөрийгөө болон бусдыг хүндлэх, өөртөө итгэлтэй байдлыг нэмэгдүүлэх, муу үлгэр дууриал, бооцоот тоглоом зэргийн хор уршиг, өөрийн үйлдлийн үр дагаврын талаар мэддэг байх, шударгаар хөдөлмөрлөх зэрэг зан чанаруудыг төлөвшүүлэхээр тусган "амьдралд шаардлагатай үр чадвар", "хариуцлагатай сурагч", эсхүл бусад хөтөлбөрийн хүрээнд судална." (West Virginia Code, Section 18-2-13).

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Программа нравственно-духовного образования «Самопознание» в Республике Казахстан, [http://bobek.kzhi\\_minashaitan\\_nirajim\\_bissmillahi\\_rahmani\\_rahim](http://bobek.kzhi_minashaitan_nirajim_bissmillahi_rahmani_rahim)
- Білім туралы, Қазақстан Республикасының 2007 жылғы 27 шілдедегі № 319 Заңы. [http://adilet.zan.kz/kaz/docs/Z070000319\\_](http://adilet.zan.kz/kaz/docs/Z070000319_)
- «ӨЗІН-ӨЗІ ТАҢУ» рухани-адамгершілік білім берудің жаңартылған бағдарламасын техникалық және кәсіптік білім беру мекемелерінде оқыту ерекшеліктері (Гуманитарлық бағыттағы мамандықтар бойынша), Жошибаева Гульнара Сағатовна <http://www.balakkk.kz/>
- Рухани-адамгершілік білім беру бағдарламасының ҚР жалпы білім беру жүйесіне ендірілуін құрылымдық-функционалды талдау, <https://articlekz.com/kk/article/17616>
- [http://www.character.org/uploads/PDFs/Misc\\_/FAQs.pdf](http://www.character.org/uploads/PDFs/Misc_/FAQs.pdf)
- [http://pure-oai.bham.ac.uk/ws/files/33442828/Character\\_Asia\\_1\\_.pdf](http://pure-oai.bham.ac.uk/ws/files/33442828/Character_Asia_1_.pdf)
- [https://www2.gwu.edu/~ccps/pop\\_moral.html](https://www2.gwu.edu/~ccps/pop_moral.html)
- <http://education.oxfordre.com/view/10.1093/acrefore/9780190264093.001.0001/acrefore-9780190264093-e-119>
- <https://www.tandfonline.com/doi/full/10.1080/03057240.2017.1285222>
- <https://labs.la.utexas.edu/adrg/files/2013/12/Lapsley-Yeager-MCE-Handbook-Chapter.pdf>
- <https://files.eric.ed.gov/fulltext/EJ1134548.pdf> 2011
- <https://files.eric.ed.gov/fulltext/EJ1095995.pdf>
- <http://character.org/more-resources/character-education-legislation/>
- <http://www.character.org/wp-content/uploads/What-States-Are-Doing.pdf>
- <http://www.ncpublicschools.org/docs/charactereducation/handbook/elements.pdf>
- <https://www.cde.ca.gov/ls/ys/ce/charactered.asp>
- <http://www.ncpublicschools.org/docs/charactereducation/handbook/content.pdf>
- <https://www.preceden.com/timelines/331129-history-of-character-education>

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН